



УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ
2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Агуулга

	Хуудас
Компанийн танилцуулга	3
Онцлох үйл явдлууд	4
Стратеги, хэтийн төлөв	6
Баянхөндий төслийн хөгжлүүлэлт болон бүтээн байгуулалтын тухай	7
Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд	9
NI 43-101 техникийн тайлан – геологийн ба үйлдвэрлэлийн нөөц	9
Хөндий Эрдсийн Дүүрэг	9
Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул	14
Хөрөнгө оруулалт	19
Санхүүгийн тайлангийн онцлох мэдээлэл	20
Үйл ажиллагааны хэлэлцүүлэг	20
4-р улирлын тухай мэдээлэл	21
Улирлын үр дүнгийн хураангуй	22
Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц	22
Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл	22
Гэрээгээр хүлээсэн үүрэг	23
Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг	23
Балансаас гадуурх зохицуулалт	24
Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж, тооцоолол	24
Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт	24
Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл	25
Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт	27
Мэргэшсэн этгээд	27
Бусад мэдээлэл	28
Хавсралт – Баянхөндийн хүдрийн хяналтын өрөмдлөгийн үр дүн	29

Энэхүү 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар боловсруулсан Удирдлагын Хэлэлцүүлэг ба Дүн Шинжилгээ (“УХДШ”) нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” эсвэл “Корпораци” гэх)-ийн 2023, 2024 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн аудитлагдсан тайлан, тэдгээрийн тодруулгуудын хамт уншигдана. Компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Канад доллараар илэрхийлж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулсан.

Энэхүү УХДШ нь “Урьдчилсан таамаглал” гэж үзэж болохуйц тодорхой мэдээгдлүүдийг агуулсан болно. Түүхэн баримтат мэдээгдлээс бусад энэхүү тайланд дурдагдах Баянхөндий ордын олборлолт болон боломжит нөөц, хайгуулын өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаа, төсөвт санхүүгийн үр дүн, Компанийн хүлээж буй үйл явдал, хөгжүүлэлт зэрэг нь алс хэтийг угтан харсан мэдээгдлүүд юм. Ийнхүү урьдчилсан таамаглал нь үндэслэлтэй таамаглалд (үүнд Компани, түүний охин компани болон харилцагч компанийн тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа, эдийн засаг, зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, геополитикийн тогтвортой байдал, ашигт малтмалын үнэ, хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал, валютын ханшны хэлбэлзэл, санхүүжилт, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн хүртээмж, ашигт малтмалын нөөц болон бодит нөөцийн тооцооны нарийвчлал зэрэгтэй холбоотой төсөөллүүдийг багтаах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) тулгуурласан хэмээн үзэж байгаа боловч эдгээр нь ирээдүйн үр дүнг баталгаажуулахгүй бөгөөд бодит үр дүн болон үйл явц нь дээрх таамаглалуудаас ихээхэн зөрж болохыг анхаарна уу. Бодит үр дүн нь дээр дурдсан урьдчилсан таамаглалаас зөрөх шалтгаан болохуйц хүчин зүйлсэд хөгжүүлэлт болон үйл ажиллагааны зардлын өөрчлөлт, зах зээл болон бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, Компани, түүний охин компани болон харилцагч компаниуд үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн геополитик болон хууль эрх зүйн нөхцөл байдал, хайгуул, үнэлгээний үр дүн, хөрөнгө, санхүүгийн тасралтгүй хүртээмжтэй байдал, эдийн засаг, зах зээл, бизнесийн ерөнхий нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлс багтана. Нэмэлт хүчин зүйлсийг Корпорацийн www.sedarplus.ca-д тавигдсан Корпорацийн жилийн мэдээ, тайлангийн “Эрсдэлийн хүчин зүйлс” хэсэгт тэмдэглэсэн болно.

Канад Улсын үнэт цаасны хуулиар тодорхойлогдох энэхүү УХДШ-д тусгасан санхүүгийн аливаа хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг Корпорацийн удирдлага тус УХДШ гарах өдрөөр баталсан болно. Ирээдүйтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээж буй болон төлөвлөж буй ажлын талаар мэдээлэх зорилгоор санхүүгийн хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг өгч байгаа юм. Ийм хэтийн төлөв, ирээдүйн мэдээллүүдийг энэхүү УХДШ-д тусгаснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Компанийн танилцуулга

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсын хязгаарлагдмал хайгуул хийгдсэн өндөр хэтийн төлөв бүхий бүсэд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй уул уурхайн компани юм. Компани нь Торонтогийн хөрөнгийн бирж (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржид (MSE:ERDN) давхар бүртгэлтэй.

Компани нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувийг эзэмшдэг бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлүүд дээр хийсэн судалгааны үр дүнд Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий Эрдсийн Дүүрэг нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогенийн бүс дэх Транс Алтайн Терреинд байрладаг. Төв Азийн Орогенийн Бүс нь БНХАУ болон Уралын нуруудын дагуу 2,500 км-ийг хамран оршдог. Энэхүү бүс нь Узбекистаны Мурунтау зэрэг дэлхийн хамгийн том алтны ордыг багтаан, хэд хэдэн порфир, порфиртой холбоотой алт, зэсийн ордуудыг агуулдаг. Энэхүү бүсийн дагуу Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт Хөндий Эрдсийн Дүүргээс 650 км зайд Рио Тинтогийн Оюу Толгой зэс-алтны орд мөн байрладаг.

Эрдэнэ Ресурс Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хайгуул хязгаарлагдмал хийгдсэн бүсэд 20 гаруй жилийн турш хайгуулын үйл ажиллагаа эрхлэн, Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Энэхүү хугацаанд Эрдэнэ Ресурс нь Алтан Нар, Баянхөндий, Хар Морин Дэл зэрэг эпитеpmаль алтны ордууд, Улаан, Хар Морь зэрэг алтны төслүүд, Зуун Мод молибдени-зэсийн порфирийн ордоос гадна хэд хэдэн хэтийн төлөв бүхий бүсүүд, хайгуулын талбайг тодорхойлсон. Эдгээр нээлтүүд нь Хөндий Эрдсийн Дүүргийн цөм бөгөөд баруун хойд зүг рүү 50*100 км талбайг хамран оршдог.

2023 оны 1-р сард Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын уул уурхайн томоохон олборлогч болох Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй Баянхөндий алтны төслийг (“Төсөл”) хөгжүүлэх зорилгоор стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан ба энэхүү гэрээг 2024 оны 1 сард эцэслэсэн. Түншлэлийн гэрээний хүрээнд ММС нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)-ийн 50%-тай тэнцэх хувьцааг эзэмших нөхцөлтэй. Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авна. Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн төслийг 100% эзэмшсэн хэвээр байна.

Стратегийн түншлэлийн гэрээг байгуулсны дараа Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий төслийн төслийн барилгын бэлтгэл ажлыг эхлүүлсэн ба 2023 оны сүүлээр эцэслэсэн. 2024 оны 1 сард Эрдэнэ Монгол нь Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх албан ёсны шийдвэрийг танилцуулсан. 2024 оны 2-р сард стратегийн түншлэлийн хүрээнд мэдээлсэн 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт болон ММС болон Эрдэнэ Ресурсийн хооронд бүтээн байгуулалтад шаардагдах 80 хүртэл сая ам.долларын санхүүжилтийн мэдээллийг танилцуулсан. 2024 оны 12 сард Эрдэнэ Монгол нь олборлолт руу шилжихэд дэмжлэг болох 50 сая ам.долларын эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг Монголын Худалдаа хөгжлийн банкнаас авч байгааг мэдээлсэн.

2024 оны эцэст Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтын гуравны хоёрыг эцэслэгдсэн буюу голлох байгууламж болох боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 67%-ийн гүйцэтгэлтэй байна. Бүх томоохон тоног төхөөрөмжийг суурилуулж дууссан ба боловсруулах үйлдвэрийн бус дэд бүтцийн ажлуудыг ахиулан ажиллаж байна. 2024 оны эцэст нийт зардал 83 сая ам.доллар болсон. Эрдэнэ Монгол ХХК-ийн удирдлагууд төслийн цар хүрээний өөрчлөлт, инфляци, цаг агаар болон тээврийн саатлаас үүдэн 100 сая ам.долларын анхны хөрөнгө оруулалтын хэмжээ 15%-иар нэмэгдэх магадлалтайг тооцоолсон. Энэхүү өөрчлөлтийг төслийн инженер, худалдан авалт, барилгын (“EPC”) цогц гэрээлэгчтэй хамтран баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байгаа ба Баянхөндий төслийн хувьд Эрдэнэ Ресурс болон ММС-ээс нэмэлт үнэт цаасны хөрөнгө оруулалт хийгдэхгүй гэж харж байна.

Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий алтны төслийг олборлолт руу шилжүүлэхэд төвлөрч ажиллахын хамт Баянхөндийг тэлэх боломжуудыг судлан, Хар Морь талбайд хэтийн төлөв бүхий зорилтод бүсүүдийг тодорхойлох ажлуудыг гүйцэтгэж байна. 2024 оны 3-р улиралд хийгдсэн хайгуулын хөтөлбөрөөр Баянхөндий ил уурхайн зэрэгцээ бүсүүдэд өндөр агуулга бүхий хүдэржилт илэрсэн. 2024 оны эцэст хүдрийн хяналтын цооног өрөмдсөн ба үр дүнг энэхүү жилийн эцсийн тайлантай зэрэгцэн танилцуулсан. Энэхүү хөтөлбөрөөр урьд нь тодорхойлсон блокуудын агуулгыг баталгаажуулахын зэрэгцээ 10 бүсэд хүдрийн блокыг тэлэх боломжтой хүдэржилтийг огтолсон.

Нэмэлт 100+ цооног өрөмдөн, дээрх шинээр илэрсэн бүсүүдийг шалгахар төлөвлөсөн. Өрөмдлөгийн үр дүнгүүдийг 2025 онд шинэчилсэн уурхайн төлөвлөгөөнд тусгана.

Түүнтэй зэрэгцэн, Эрдэнэ Ресурс нь Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэг болох Зуун Мод төслийн хайгуулыг амжилттай ахиулж байна. 2023 онд төслийн талбайд 4,100 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн. Өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн цооногоор өнөөгийн нөөцийн хязгаарыг тэлсэн бөгөөд ордын төв бүсийн интервалуудад дунджаас өндөр агуулга огтолсон. Мөн, ордоос хойд зүгт 1.7 км зайд нөөцийн зэрэг бүхий хүдэржилт илэрсэн нь энэхүү томоохон молибден-зэсийн цогцолбор нь бүх чиглэлд нээлттэй илтгэж байна. 2024 оны дундуур гүйцэтгэсэн гадаргын чулуулгийн дээжлэлтээр Зуун Мод молибден-зэсийн ордоос баруун зүгт 4.5 км-т алтны шинэ хэтийн төлөв бүхий талбайг нээн илрүүлсэн.

Эрдэнэ Ресурс нь цаашид Хөндий Эрдсийн Дүүргийн орчимд хөрөнгө оруулалт хийн, нөөцийг нэмэгдүүлэх боломжуудыг судалж байна. Хөндий Эрдсийн Дүүрэг нь зэс-молибденийн порфир, дунд зэргийн сульфиджилт/карбонат суурь бүхий металлын ордууд, сульфиджилт багатай эпитеpmаль алт, алт-мөнгөний орд гэх суурь ба үнэт металлын бүрэн спектрийг агуулдаг. Эрдэнэ Ресурс нь урт хугацаанд Монголын баруун өмнөд хэсэгт үйл ажиллагаа явуулж буй компани бөгөөд өндөр хэтийн төлөв бүхий талбайг үргэлжлүүлэн тэлэх зорилтыг баримтлан ажиллаж байна.

Онцлох үйл явдлууд

Баянхөндий алтны төсөл

- 2024 оны 1-р сарын 15-нд Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын албан ёсны шийдвэрийг гаргасан.
 - Төслийн инженерчлэл, худалдан авалт, барилгын ("EPC") цогц гэрээг Монголын тэргүүлэгч барилгын компани болох MCS Property ХХК ("MCSP")-тэй байгуулсан.
 - 240 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам барьж эрчим хүч худалдан авах гэрээ ("PPA")-г MCS International LLC ("MCSI")-тэй байгуулсан.
- 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар бүтээн байгуулалтын явц 66%-ийн гүйцэтгэлтэй байна.
 - 2024 оны 4-р улирлын эцэс хүртэл нийт 83 сая ам.долларын зардал гарсан.
 - Эрдэнэ Монгол ХХК-ийн удирдлагын тооцооллоор анхны 100 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй харьцуулахад төслийн цар хүрээний өөрчлөлт, тээвэр болон цаг уураас үүдэлтэй саатлуудаас шалтгаалан хөрөнгө оруулалтын зардал ойролцоогоор 15%-аар нэмэгдэх магадлалтай байна. Гэсэн хэдий ч, Баянхөндий төсөлд Эрдэнэ Ресурс болон MMC-ээс нэмэлт санхүүжилт хийх шаардлагагүй гэж үзэж байна.
 - Төслийн гол байгууламж болох боловсруулах үйлдвэрийн барилга жилийн эцэст 67%-ийн гүйцэтгэлтэй байна. Бетон цутгалтын болон структурын ажлуудыг эцэслэн, голлох тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан.
 - Боловсруулах үйлдвэрийн бус барилга байгууламжуудын гүйцэтгэл 60%, дэд бүтцийн байгууламжууд 80%, цахилгаан хангамжийн байгууламжууд 52%-ийн гүйцэтгэлтэй буюу ерөнхийдөө хуваарийн дагуу үргэлжилж байна.
 - Хаягдлын нэгдсэн байгууламжийг 2024 оны 4-р улиралд улсын комисст хүлээлгэн өгч, үлдсэн барилга байгууламжийг 2025 оны 1, 2-р улиралд шат дараатайгаар ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн.
 - Бүтээн байгуулалтын дийлэнх байгууламжийг 2025 оны 5-р сард эцэслэн, боловсруулах үйлдвэрийг 2025 оны 2-р улиралд улсын комисст хүлээлгэн өгч, 2025 оны 3-р улиралд алтны олборлолтыг эхлүүлэхээр төлөвлөсөн.
- Орон нутаг болон оролцогч талуудын хамтын ажиллагааны ажлын хүрээнд:
 - Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 2024 онд төлөвлөсөн орон нутгийн хөгжлийн төсөл хөтөлбөрийг дэмжин ажилласан.
 - Баянхөндий уурхайд ажиллах хүний нөөцийг бэлтгэх зорилгоор хүнд машин механизмын операторын сургалтыг 8 удаа зохион байгуулж, орон нутгийн 164 иргэдийг хамруулсан ба MMC-ийн Ухаа худаг уурхайд дадлагажин, ажиллаж байна.
 - Компани нь орон нутгийн иргэдийн усны хүртээмжийг нэмэгдүүлэхээр гурван худаг шинээр гаргаж, засварлан шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуулын ажил

- Баянхөндий ордод 15,000 метрийн хүдрийн хяналтын өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэсэн
 - Уурхайн эхний 3-4 сард олборлолт хийгдэх газрын гадаргад ойр хэсгийн, өндөр агуулга бүхий бүсүүдэд төвлөрч 89 гүехэн баганат өрөмдлөгийн цооног өрөмдсөн ба түүнээс гадна 456 метрийн 10 цооногийг ирээдүйн уурхайн төлөвлөгөөнд ашиглахаар өрөмдсөн.

- Хөтөлбөрийн хоёрдугаар үе шатыг 2024 оны 4-р улиралд гүйцэтгэсэн ба нийт 1168 метрийн 106 баганат өрөмдлөгийн цооног, 12273 метрийн 812 урвуу үлээлгэт хийн цохилтот эргэлтэт өрөмдлөгийн цооног өрөмдсөн ба жилийн эцсийн тайланг танилцуулахтай зэрэгцэн үр дүнг хүлээн авч, доор онцлох үр дүнг танилцуулав.
- Үр дүнгээр өнөөгийн блок моделийн загвар болон тэлэх боломжит бүсүүд дэх өндөр агуулга бүхий бүсүүдийг баталж, цооногийн 7 метрээс эхлэн 101.0 г/т алтны агуулга бүхий 4 метр интервал, цооногийн 11 метрээс эхлэн 115.1 г/т алтны агуулга бүхий 4 метр интервал (20 грамм/метр-ээс дээш өндөр агуулга бүхий интервалуудыг хүснэгтээс харна уу) огтолсон.
- Төлөвлөсөн уурхайн зэрэгцээ Баянхөндий ордыг тэлэх боломжийг судлах 950 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлсэн.
 - Өрөмдлөгөөр бүх цооногт алтны хүдэржилт огтолсон нь нөөцийг нэмэгдүүлэх, уурхайн хязгаарыг тэлэх боломжийг харууллаа.
 - Үр дүнгүүдэд Баянхөндий ил уурхайтай зэрэгцээ орших Баруун Страйкер бүсэд тус төслийн хамгийн өндөр агуулгыг танилцуулсан ба үүнд 7.3 г/т алтны агуулга бүхий 42 метрийг огтолсонд 15-аас 79 г/т алтны агуулга бүхий хэд хэдэн интервал багтаж байна. (BKD-377 цооног)
- Хар Морь болон Зуун Мод талбайд гадаргын дээжлэлтийн хөтөлбөр гүйцэтгэсэн.
 - Хар Морь талбайн хэд хэдэн дээжид өндөр алтны (37.7 г/т алтны агуулга хүртэл) болон мөнгөний (100 г/т мөнгөний агуулгаас дээш) агуулга илэрсэн бөгөөд ирээдүйн хөтөлбөр хэрэгжүүлэх талбайг тодорхойллоо.
 - Зуун Мод молибден-зэсийн ордоос баруун зүгт 4.5 км зайд алтны хэтийн төлөв бүхий шинэ талбайг илрүүлсэн.
- Хайгуулын багт дэмжлэг үзүүлэх техникийн зөвлөхөөр Келли Клуэрийг томилсон.
 - Келли Клуэр нь 30 гаруй жилийн туршлагатай, үүнээс 10 гаруй жилийг Монгол Улсад алтны томоохон хоёр ордыг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд төвлөрч ажилласан.

Компанийн тухай

- 2024 оны 1-р сарын 23-ны өдөр Монголиан Майнинг Корпорэйшн (“MMC”)-тэй байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээг эцэслэв.
 - Баянхөндий төслийг эзэмшдэг ЭМ компанийн 50%-ийг эзэмших нөхцөлөөр MMC нь 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.
 - Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-ийг эзэмшихээс гадна Хөндий Эрдсийн Дүүргийн 400,000 унц давсан олборлолтоос 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй. Мөн Зуун Мод молибден-зэсийн ордыг 100% эзэмшсэн хэвээр байна.
- Баянхөндий төслийн санхүүжилтийг стратегийн түнш MMC-ээс татан төвлөрүүлэх гэрээг байгуулсан.
 - Эрдэнэ Ресурс болон MMC хамтран эзэмшдэг ЭМ-д хувьцаа эзэмшигчийн зээл хэлбэрээр 80 сая ам.доллар хүртэлх төслийн санхүүжилтийг татан төвлөрүүлэх гэрээ байгуулсан.
 - 5 жилийн хугацаатай, жилийн 13.8%-ийн хүүтэй ба зээлийн хугацаа дуусахад бүрэн төлсөн байх нөхцөлтэй.
 - Барьцаа хөрөнгө нь Эрдэнэ Ресурсийн ЭМ дахь 50%-ийн эзэмшил болон бусад өмчийн давуу эрхээр баталгаажсан.
- Монголын Худалдаа хөгжлийн банкнаас 50 сая ам.долларын зээл авахаар гэрээ хийсэн.
 - Зээл нь 24 сарын хугацаатай ба зээлийн эцсийн зургаан сарын хугацаанд сар бүр ижил хэмжээний эргэн төлөлт хийх нөхцөлтэй.
 - Зээл нь жилийн 13.3%-ийн хүүтэй бөгөөд Баянхөндий төслийн боловсруулах үйлдвэрийн барилга, хөрөнгөөр баталгаажсан.
- 2024 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон тайлант жилийн хугацаанд \$8,245,886-ын цэвэр алдагдалтай байсан ба 2023 оны 12 сарын 31-ний өдөр \$522,043-ын цэвэр ашигтай байв.
 - 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэг жилийн хугацаанд хайгуул, үнэлгээний зардал \$1,852,642 байсан нь 2023 оны мөн үеийн \$847,010-тай харьцуулахад өссөн. Энэ нь цалин урамшуулал, мэргэжилтний зардал болон томилолтын зардлуудыг

Баянхөндий төсөлд капиталжуулдаг байсан бол стратегийн түншлэлийг эцэслэснээр зарлагадсантай холбоотой.

- 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд компанийн ерөнхий болон захиргааны зардал 5,043,058 ам.долларт хүрсэн нь 2023 оны мөн үеийн 3,137,735 ам.долларын зардалтай харьцуулахад өссөн үзүүлэлт. Энэ нь ММС-тэй байгуулсан зээлийн гэрээг эцэслэсэнтэй холбоотойгоор өмнө нь хойшлуулсан төслийн санхүүжилт болон бусад холбогдох зардлыг бүртгэлээс хассан, мөн тухайн жилийн амьдралын өртгөөс үүдсэн цалингийн зардлын өсөлт, анхны алт олборлохтой холбоотой удирдах ажилтнуудын урамшууллын хуримтлал зэрэгтэй холбоотой.
- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүдсэн алдагдал 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон нэг жилийн хугацаанд \$3,245,109 байсан ба өнгөрсөн оны мөн үед \$2,278,370 байв. Энэ нь 2024 оны 2-р сард Эрдэнэ Монгол ХХК-д оруулсан санхүүжилтийн капиталжуулаагүй хүүгийн өсөлтийг стратегийн түншлэлийг эцэслэсэнтэй холбоотой Эрдэнэ Ресурсийн өмчлөлд орсон өөрчлөлтөөр хэсэгчлэн нөхсөнтэй холбоотой.
- 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон нэг жилийн хугацаанд ММС-тэй стратегийн түншлэлийг эцэслэснээр \$1,256,598-ын бэлэн бус, эзэмшлийн хувь хэмжээ буурахтай холбоотой ашиг бүртгэгдсэн ба 2023 оны 1-р сард стратегийн түншлэлийн гэрээ зурагдсанаар Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтад өөрчлөлт гарснаас үүдсэн ашиг \$6,544,863 байв.

Стратеги, хэтийн төлөв

Эрдэнэ Ресурс нь Хөндий Эрдсийн Дүүрэг дэх үнэт болон суурь металлын ордуудыг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Эрдэнэ Ресурсийн стратегийн зорилтуудад Баянхөндий алтны төслийг олборлолтын шат руу ахиулах болон хайгуул, хөрөнгө оруулалтад тулгуурлан Хөндий Эрдсийн Дүүрэг дэх ордуудыг тэлэн, хөгжүүлэхэд оршино.

2024 оны 1 сард Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлэхээр ММС-тэй байгуулсан стратегийн түншлэлийн гэрээ эцэслэгдсэн. ММС нь Монголын нүүрсний салбарт баяжуулсан коксжих нүүрс олборлон, экспортлогч, хувийн хэвшлийн хамгийн том төлөөлөл. ММС нь Монгол Улсын Өмнөговь аймагт байрлах Ухаа худаг (“УХ”), Баруун наран (“БН”) коксжих нүүрсний уурхайд тус тус үйл ажиллагаа явуулдаг. Тус компанийн хувьцаа Хонконгийн хөрөнгийн биржид (НКЕХ:975) нээлттэй арилжаалагддаг бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ одоогоор ойролцоогоор 1 тэрбум ам.доллар байна.

ММС-ийн гол хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын тэргүүлэгч групп компаниудын нэг болох М-Си-Эс Групп юм. М-Си-Эс нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсад инженерчлэл, барилга, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэнд, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ирсэн бөгөөд нийт 13,000 гаруй ажилтантай, Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг.

Эрдэнэ Ресурсийн геологи хайгуул, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын чадвар, ММС-ийн олборлолт болон үйл ажиллагааны туршлага, М-Си-Эс групп компаниудын инженерчлэл, дэд бүтэц, эрчим хүчний шийдлүүдийг хангах боломжуудыг нэгтгэн, Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлж, бүх оролцогч талуудад өгөөжийг бий болгох боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Эрдэнэ Ресурс болон ММС нь бүтээн байгуулалтын албан ёсны шийдвэрийг 2024 оны эхээр гаргасан. Төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын (“ЕРС”) үйлчилгээний гэрээг MCS Property (“MCSP”), эрчим хүч худалдан авах гэрээ (“PPA”)–г MCS international (“MCSI”) компанитай хийсэн. Бүтээн байгуулалтын хүрээнд төслийн талбайд 650 орчим ажилтан ажиллаж байна. Бүтээн байгуулалт ерөнхийдөө хуваарийн дагуу явж байгаа ба хил дээр ачаалал үүсэж, хөдөлмөрийн өрсөлдөөн нэмэгдсэн, цаг агаарын хүнд (хүчтэй аадар бороо, энгийнээс өндөр температур зэрэг) нөхцөл нь зарим бэрхшээлийг үүсгэж байна. Бүтээн байгуулалт 2025 оны 2-р улиралд эцэслэгдэн, 2025 оны 3-р улиралд анхны алтыг олборлохоор төлөвлөсөн.

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн хайгуулын үр дүнд илрүүлсэн Баянхөндий орд, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай, Улаан талбайг багтаасан Хөндий-Улаан томоохон хувирлын бүс нь алт агуулсан гидротермаль системийн нэг хэсэг бөгөөд олон сая унцын нөөц бүхий ордуудыг агуулах боломжтойг харуулж байна. 2024 оны 3-р улиралд нийт 950 метрийн 6 алмазан цооног өрөмдсөн ба энэ нь Баянхөндийн төлөвлөсөн ил уурхайн баруун болон хойд бүсэд газрын дөт гүний нөөцийг тэлэх боломжийг судлахаар гүйцэтгэсэн. Бүх цооногт алтны хүдэржилтийг огтолсон ба үүнд Баянхөндий ил уурхайн баруун хэсэг болон Баруун Страйкер бүсэд илэрсэн хамгийн өндөр агуулга багтаж байна.

Үүнд: 7.3 г/т алтны агуулга бүхий 42 метр огтолсон нь хэд хэдэн 15-аас 79 г/т хүртэл өндөр агуулгатай нэг метрийн интервалуудыг багтаасан (BKD-377). Дээрх цооногоос хойд зүгт 110 метрт орших хоёр дахь цооногт өнөөгийн ил уурхайн хязгаараас гадна маш сайн үр дүнгүүд илэрсэн, үүнд: цооногийн 178 метрээс 6.1 г/т алтны агуулга бүхий 22 метр багтаж байна. Уурхайн хойд хязгаарт (BKD-381) хүдрийн агуулгын хүдэржилт огтолж, хойд зүгт үргэлжлэн нөөцийн моделд тодорхойлсноос илүү гүехэн гүнээс эхэлж байна. Үүнд: 16.9, 56.8, 78.1 ба 11.1 г/т алтны агуулга бүхий нэг метрийн интервалууд багтаасан 4.1 г/т алтны агуулга бүхий 54 метр багтаж байна. Түүнээс гадна Хар Морь, Улаан талбайд хийгдсэн хайгуулын хөтөлбөрөөр шинэ зорилтот бүсүүдийг тодорхойлсон.

2023 онд Эрдэнэ Ресурс нь Ази тивийн хамгийн том хөгжүүлэлт хийгдээгүй молибден-зэсийн ордуудын нэг Зуун Мод төслийг хөгжүүлэхээр 4100 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлж дууссан. Хайгуулын хөтөлбөрөөс гадна Эрдэнэ Ресурс нь RPMGlobal (Minarco-Mine Consult)-аас хийсэн урьдчилсан үнэлгээ дээр тулгуурлан ирэх саруудад зах зээл, техник, эдийн засгийн судалгаа, тусгай зөвшөөрөл авах ажлуудыг гүйцэтгэнэ. Тусгай зөвшөөрлийн талбайд Зуун Мод төслөөс гадна хэд хэдэн зэс ба молибденийн хэтийн төлөв бүхий талбай багтдаг. Зуун Мод порфирийн цогцолборын хойд хэсэгт байрлах Хөвийн Хар талбай нь филлийн ба калийн хувирлын кварц монзонит ба гранодиоритын интрузив бүхий хэдэн км зайд тархсан зэсийн хүдэржилт бүхий томоохон талбайг хамардаг. Өргөн зайтай өрөмдсөн өрөмдлөгөөр зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүсүүдийг огтолсон ба ZMD-121 цооногт 308-аас 342 метрт 1.3% зэс, 9.24 г/т мөнгөний агуулга бүхий 34 метрийн интервал огтолсон. Зуун Мод порфирийн томоохон цогцолборт хязгаарлагдмал судалгаа хийсэн ба удирдлагууд тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийг нэмэгдүүлэх хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбай байгаа хэмээн тодорхойлсон.

Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөв бүхий 20 гаруй талбайг тодорхойлсон ба дээрх судалгаанд тулгуурлан Хөндий Эрдсийн Дүүрэгт сонгон шалгаруулалтад идэвхитэй оролцох төлөвлөгөөтэй байна. Мөн компани нь өнгөрсөн хугацааны хайгуулын туршлагад тулгуурлан үнэт болон суурь металлын нөөц бүхий боломжит бүс нутгуудыг тодорхойлохоор ажиллана.

Баянхөндий төслийн хөгжлүүлэлт болон бүтээн байгуулалт

2023 оны сүүлээр бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эцэслэснээр 2024 оны 1-р сард Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндийн бүтээн байгуулалтын албан ёсны шийдвэрийг гаргасан. 2024 оны эцэст төслийн талбайд 430 ажилтан ажиллаж байна. 2024 оны 10-р сард төслийн хөдөлмөрийн чадвар түр алдалт анх бүртгэгдэн, жилийн нийт бүртгэгдсэн гэмтлийн давтамж 2024 оны хувьд 200,000 хүн цаг тутамд 0.6 болсон.

Төслийн талбайд байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн тохиолдол бүртгэгдээгүй. Байгаль орчны удирдлагын хүрээнд байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжин, хоёр га байгууламжид орон нутгийн онцлог ургамлуудыг тарьж ургуулж байна.

Хуваарь болон төсөв

2024 онц эцэст төслийн бүтээн байгуулалтын гүйцэтгэл 66%-тай болсон ба үүнд Баянхөндий төслийн голлох байгууламж болох боловсруулах үйлдвэр 67%-тай үргэлжилж байна. Дийлэнх байгууламжуудыг 2025 оны 1,2-р улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Боловсруулах үйлдвэрийг 2025 оны 5 сард ашиглалтад оруулан, 2025 оны 3-р улиралд анхны алтыг олборлохоор төлөвлөсөн.

2024 оны 12 сарын 31-ний байдлаар ТЭЗҮ (2023)-д тусгагдсан төслийн зардал болох 100 сая ам.доллараас одоогийн байдлаар 83 сая ам.долларыг зарцуулсан. Удирдлагууд төслийн цар хүрээний өөрчлөлт, инфляц, цаг агаар болон тээврийн саатлаас үүдэн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ 15%-иар нэмэгдэх магадлалтайг тооцоолсон. 2024 оны 12 сард авсан Худалдаа хөгжлийн банкны эргэлтийн хөрөнгийн зээлийг багтаан ЭМ-ын одоогийн санхүүгийн нөхцөл нь хувьцаа эзэмшигчдээс хувьцааны хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхгүйгээр бүтээн байгуулалтыг эцэслэн, ашиглалтад оруулах боломжтой гэж харж байна.

Боловсруулах үйлдвэр

2023 онд бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд боловсруулах үйлдвэрийн газар шорооны ажлыг эхлүүлсэн ба нунтаглах, бутлах хэлхээг эцэслэж, 2024 оны нэгдүгээр улиралд буталсан хүдрийн дамжуургын суурийн малталтыг эхлүүлсэн. 2024 оны 12 сарын 31-нд боловсруулах үйлдвэрийн төмөр бетоны ажлуудыг эцэслэн, оны эцэст нийт 16,000м³ бетон цутгасан.

Ган структур, танкны тоног төхөөрөмжүүд нэгдүгээр улиралд төслийн талбайд хүргэгдэж, 2024 оны 3-р сард боловсруулах үйлдвэрийн ган хийцийн угсралтыг эхлүүлсэн. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар ган хийцийн угсралтын 90%-ийг эцэслэсэн. Танк суурилуулах ажил үргэлжлэн, уусгалтын хэсгийг эцэслэсэн ба үйлдвэрийн хаягдлыг усгүйжүүлэх хэсэг 60%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хагас өөрөө нунтаглах тээрэм (sag mill) болон бөмбөлөгт тээрэм (ball mill) -ийн тоног төхөөрөмжүүдийн угсралт 2024 оны 3-р улиралд дууссан. Хуваарийн дагуу өтгөрүүлэгчийн угсралт 90%-тай явж байна. Бутлуурын суурилуулалтын ажил 30%, даралтат шүүлтүүр 50%-ийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны эцэст архитектурын зураглал, шугам хоолой болон цахилгааны угсралтын ажлууд хуваарийн дагуу буюу тус бүр 16%, 6% болон 15%-ийн гүйцэтгэлтэй байна.

Боловсруулах үйлдвэрийн бус дэд бүтэц

2024 оны 1-р улиралд боловсруулах үйлдвэрийн бус барилгуудын газар шорооны ажлыг гүйцэтгэсэн. Сорьцын лаборатори, агуулахын барилга, харуул хамгаалалтын байр, захиргааны байрны структурын угсралтууд 4-р улиралд дууссан. Кемп, засварын цех, химийн бодисын агуулах, ус хангамжийн систем, инженерийн шугам сүлжээний ажлууд 2-р улиралд эхэлсэн бөгөөд улирлын эцэст гүйцэтгэл 43%-д хүрсэн. Архитектурын зураглал, шугам хоолой, халаалт, агааржуулалт ("HVAC") болон цахилгааны ажлууд нь боловсруулах үйлдвэрийн бус дэд бүтцийн байгууламжуудад үргэлжилсээр байна. Цахилгаан хангамжийн угсралтын ажлууд хуваарийн дагуу үргэлжилж, улирлын эцэст 52% гүйцэтгэлтэй байгаа ба 2025 оны 2-р улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

Уулын ажлууд

Өнөөг хүртэл Баянхөндийгөөс бүтээн байгуулалтын зориулалтаар 35,000 тонн материалыг шилжүүлсэн. 2024 оны 4-р улиралд уулын аливаа ажил хийгдээгүй. Барилгын материалын газар шорооны ажил болон зөөвөрлөлтийг төслийн гүйцэтгэгч гүйцэтгэж байна.

Төслийн нэгдсэн хаягдлын байгууламж ("IWF")-ийг 2024 оны 3-р улирлаас эхлэн байгуулсан. Нэгдсэн хаягдлын байгууламжид боловсруулах үйлдвэрийн хуурай хаягдлыг (15% чийгшил бүхий) уурхайн хаягдал чулуулгийн дунд доторлон байршуулна. Нэгдсэн хаягдлын байгууламжийг гурван үе шаттайгаар байгуулах ба эхний үе шатанд 12 сараас доошгүй хугацаанд хаягдлыг байрлуулах хүчин чадалтай. Хаягдлын нэгдсэн байгууламжийн эхний үе шатыг 2024 оны 12 сард ашиглалтад оруулсан.

Бүтээн байгуулалттай холбоотой тусгай зөвшөөрлүүд

Төсөлтэй холбоотой ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, газар ба усны зөвшөөрөл зэрэг голлох тусгай зөвшөөрлүүдийг авсан. Боловсруулах үйлдвэр зэрэг дийлэнх барилга байгууламжийн зураг төсөл, барилгын зөвшөөрлүүдийг авсан.

Уурхайг гурван үе шаттайгаар ашиглалтад оруулах ба үүнд: техникийн барилга угсралт, уурхайн үйл ажиллагаа болон боловсруулалт, химийн бодисын тусгай зөвшөөрөл багтана. Холбогдох шалгалт, туршилтын шаардлагыг хангаснаар барилга байгууламжуудыг багцаар ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийг ашиглалтад оруулах ажлууд 2024 оны 4-р улирлаас эхлэн 2025 оны 2-р улирлыг дуустал үргэлжлэх ба 2025 оны 3-р улиралд анхны алтыг олборлохоор төлөвлөж байна.

Хүний нөөц

Дөрөвдүгээр улирлын эцэст төслийн талбайд гүйцэтгэгчдийн баг бүрэлдэхүүнийг оролцуулан 430 ажилтан ажиллаж байна. Төслийн талбайд ажиллаж буй ажилтнуудын 30% нь Баянхонгор аймгийн иргэд, тэднээс олонх нь Баянхөндий төсөл оршиж буй Шинэжинст сумын иргэд байна. Төслийн ажилтнуудын 15% нь эмэгтэйчүүд байна.

Орон нутгийн төсөл хөтөлбөрүүд

Төслийн талбайд ажлын байраар хангахаас гадна, компани нь Баянхонгор аймгийн иргэдийг ММС-тэй хамтран уул уурхайн тоног төхөөрөмжийн операторын сургалтад хамруулж байна. Өнөөг хүртэл 160 гаруй иргэдийг сургалтад хамруулсан бөгөөд суралцагчдын 90% нь ММС-ийн Ухаа худаг уурхайд операторын чиглэлээр үндсэн ажилтнаар ажиллаж, туршлага хуримтлуулж байна. 2025 оны 2-р улиралд уулын ажил эхэлснээр дээрх операторууд Баянхөндий төсөл дээр ажиллаж эхэлнэ. 2025 онд дахин 2 ээлжийн сургалтыг төлөвлөсөн ба нийт 200 иргэн операторын сургалтад хамрагдаж дуусна.

Компани нь Баянхөндий төсөл хэрэгжих аймаг болон сумдын засаг захиргааны байгууллагатай Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд 2024 онд дэд бүтэц, боловсрол болон эрүүл мэнд зэрэг орон нутгийн хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд 450,000 ам.долларын санхүүжилт олгосон.

Түүнээс гадна, Эрдэнэ Монгол нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлтэй хамтран ажиллаж, орон нутгийн худалдан авалтыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, орон нутгийн оюутан залуусын боловсролыг дэмжих зэрэг төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн орон нутгийн иргэдийн усны хүртээмжийг нэмэгдүүлэхээр орон нутагт гурван худаг суурилуулах, сайжруулах ажлуудыг гүйцэтгэсэн.


Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд

NI 43-101 Техникийн тайлангууд– Геологийн ба үйлдвэрлэлийн нөөц

2018 оны 9 сарын 15-нд Компани нь Хөндий алтны төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг танилцуулсан. Компани нь NI 43-101 ("NI 43-101")-д заасан "Ашигт малтмалын төслийн ил тод байдлын стандарт"-д заасан стандартын дагуу техникийн тайланг бэлтгэдэг. 2023 оны 8 сарын 15-ны өдөр боловсруулсан тайланг "Баянхөндий алтны төсөл, шинэчилсэн ТЭЗҮ, NI 43-101 техникийн тайлан" нэртэйгээр 2023 оны 9 сарын 25-нд танилцуулсан.

Алтан Нар, Хар Морь болон Зуун Модын ордоос бусад Компанийн эзэмшлийн хайгуулын талбай нь хайгуулын эхний шатанд явж буй бөгөөд NI 43-101 тайлагналын стандартын дагуу тайлагнах нөөцийн тайланг боловсруулаагүй. Дээр дурдсан ордуудаас гадна энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээнд дурдсан талбайн боломжит агуулга болон хэмжээ нь урьдчилан таамагласан таамаглал бөгөөд нөөцийн тайланг боловсруулах хэмжээний хайгуулын судалгаа хийгдээгүй болно. Компанийн төслүүдийн тухай нэмэлт мэдээллийг www.sedarplus.ca, SEDAR+ дахь компанийн хуудаснаас NI 43-101 техникийн тайлан, жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлүүдээс ("AIF") авч танилцах боломжтой.

Хөндий Эрдсийн Дүүрэг



Хөндий Эрдсийн Дүүрэг нь компанийн газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий Баянхөндий, Хар Морь ба Алтан Нар орд, Зүүн Өмнөд Улаан, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай болон Зуун Мод молибден-зэсийн ордоос бүрддэг.

Баянхөндий ("Rich Valley") алтны орд нь 2309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийг Эрдэнэ Ресурсийн охин компани Эрдэнэ Монгол ХХК эзэмшдэг. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөлд Баянхөндий, Хар Морь төслүүд багтдаг ба нөөцийг "Bayan Khundii Gold Project, Feasibility Study Update, NI 43-101 Technical Report"-д тусгасан болно.

Баянхөндий алтны төсөл

2023 оны 8-р сарын 15-нд Эрдэнэ Ресурс нь Баянхөндий алтны төслийн нарийвчилсан ТЭЗҮ-г боловсруулсан. Энэхүү хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2023 оны 9 сарын 25-нд NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай олон улсын ба Монголын мэргэжлийн зөвлөх байгууллагууд хамтран боловсруулсан ба "Bayan Khundii Gold Project Feasibility Study Update, NI 43-101 Technical Report" нэртэйгээр танилцуулсан. Тайланд: нарийвчилсан уурхайн загварчлал, уулын ажлын хуваарь, боловсруулах

үйлдвэрийн анхан шатны инженерийн загварчлал (“FEED”), уурхайн дэд бүтэц, гидрогеологийн үнэлгээ, нэгдсэн хаягдлын байгууламжийн загварчлал, хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны дэлгэрэнгүй зардал, тооцоолол болон эдийн засгийн шинэчилсэн загварчлалыг танилцуулсан.

2023 оны шинэчилсэн ТЭЗҮ-д газрын дөт гүн дэх өндөр агуулга бүхий Баянхөндий ордыг ил аргаар олборлохдоо ордын өмнөд хэсгээс хойш (Страйкер болон Алтан Толгой), залгаа орших Мидфийлд болон Зүүн-Хойд Мидфийлд бүсүүдийг үргэлжлүүлэн хойд зүгт чиглэн олборлохоор төлөвлөсөн. Хөгжүүлэлтийн төлөвлөгөө нь уламжлалт нүүрсэнд уусгах технологиор (“CIP”) өдөрт дунджаар 1950 тонн хүдэр боловсруулах үйлдвэрт суурилсан. 2023 оны нарийвчилсан ТЭЗҮ-д Баянхөндий төслийн 4.0 г/т алтны агуулга бүхий 4.0 сая тонн хүдэр багтсан бөгөөд эдгээр нь бүгд батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (Proven and Probable Reserves) юм. Баянхөндийн нарийвчилсан ТЭЗҮ-д тусгагдсанаар, жилд 650,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээх хүчин чадал бүхий ил уурхайг төлөвлөж байна. Олборлох боломжтой хэмжээг 4.0 сая тонн, үүнд 4.0 г/т дундаж агуулга бүхий хүдэр багтсан бөгөөд хөрс хуулалтын харьцаа 10.9:1 байна (тонн хаягдал: тонн үйлдвэр тэжээх хүдэр). Хүдэржилт нь газрын дөт гүнд буюу хүдрийн дийлэнх хэсэг нь газрын гадаргаас доош 100 метрийн гүнд байна. Ордын бүтэц, агуулга болон гүнээс шалтгаалан ил уурхайн аргаар ашиглах боломжтой. Одоогийн төлөвлөж буй ил уурхайгаас доош далд уурхайн ашиглалт нь ТЭЗҮ-д багтаагүй бөгөөд ирээдүйд судалгаа хийгдэх боломжтой. Ашиглалтын үед урвуу хутгуурт гидравлик экскаватор ашиглана. Тэсэлсэн хөрс, материалыг автосамосвалд ачин, хаягдал материалыг уурхайтай залгаа орших хаягдлын нэгдсэн овоолгод хуримтлуулан, хүдрийг боловсруулах үйлдвэрийн дэргэдэх тээрэм эсвэл хүдрийн овоолго руу шилжүүлнэ.

2023 онд шинэчилсэн ТЭЗҮ дэх Баянхөндий төслийн геологийн нөөцийн тооцооллыг (“Mineral Resource”) AGP Mining Consultants Inc. (“AGP”) NI 43-101 болон CIM стандартын дагуу боловсруулсан бөгөөд 2023 оны 4 дугаар сарын 20-нд батлагдсан. Баянхөндий төслийн геологийн нөөцийг NI 43-101-т тодорхойлсон мэргэшсэн этгээд болох Paul Daigle, P.Geo боловсруулсан.

Геологийн нөөцийг төлөвлөж буй ил уурхайн ханаар хязгаарлан, хэд хэдэн захын агуулгад тулгуурлан тооцоолсон боловч 0.40 г/т захын агуулгыг ашигласан. Захын агуулгын тооцооллууд болон төсөөллүүдийг доорх хүснэгт ба тэмдэглэлүүдэд танилцуулсан.

Баянхөндий алтны төсөл – Геологийн нөөцийн тооцооллын хураангуй, 2023 оны 4-р сар

Ангилал	Хэмжээ (сая.т)	Алтны агуулга (Au г/т)	Унц алт (мян.унц)	Мөнгөний агуулга (Ag г/т)	Унц мөнгө (мян.унц)
Баттай	4.0	3.03	394	1.44	187
Бодитой	3.3	2.04	219	1.22	131
Баттай ба Бодитой	7.4	2.58	613	1.34	319
Боломжтой	0.2	1.08	6	1.32	8

Тэмдэглэл:

1. Геологийн нөөц нь эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй.
2. Бүхэлдсэн дүн нь нийлбэр дүнд нөлөөлж болзошгүй.
3. Геологийн нөөцийн батлагдсан огноо: 2023 оны 4 сарын 20
4. Ил уурхайн геологийн нөөц нь уурхайн ханын хязгаарын оновчлолд багтсан.
5. Дараах үзүүлэлтэд тулгуурлан ил уурхайн захын алтны агуулгыг 0.4 г/т тооцсон:
 - Алтны үнийг нэг унц нь US\$2,000-аар тооцоолов.
 - Алт авалт 95%
 - Олборлолтын зардал нэг тонн тутамд \$3.00
 - Олборлолтын зардал болон ерөнхий, захиргааны зардал нэг тонн тутамд \$22.00
 - Нэгдмэл утгад 1м-т алтны агуулгыг 200 г/т, мөнгөний агуулгыг 50 г/т-оор хязгаарласан.
 - Нягтаршил нь литологиос хамааран 2.58 г/см3 - 2.66 г/см3 хооронд хэлбэлзэнэ.

Хар Морин Дэл ордын геологийн нөөцийн тооцоолол

2023 онд шинэчилсэн ТЭЗҮ-д Компани нь Баянхөндий алтны ордоос хойд зүгт 2 км-ийн зайд орших Хар Морин Дэл алтны орд (“Dark Horse Mineral Resource”)–ын анхан шатны геологийн нөөцийн тооцооллын тоймыг танилцуулж буйдаа таатай байна. Хар Морин геологийн нөөцийн тооцооллыг (“Mineral Resource”) RPM Global (“RPM”) NI 43-101 болон CIM стандартын дагуу боловсруулсан бөгөөд 2022 оны 11 дугаар сарын 02-нд батлагдсан.

Хар Морин геологийн нөөцийн захын агуулгыг тооцохдоо исэлдсэн болон шилжилтийн хүдрийн хүрээнд 0.35 г/т алтны агуулга, анхдагч хүдрийн хүрээнд 1.02 г/т байхаар тооцоолсон. Геологийн нөөцийг төлөвлөж буй ил уурхайн ханаар хязгаарласан. Захын агуулгын тооцооллууд болон төсөөллүүдийг доорх хүснэгт ба тэмдэглэлүүдэд танилцуулав.

Хар Морь алтны орд – Геологийн нөөцийн тооцооллын хураангуй, 2022 оны 11-р сар

Хүдрийн төрөл	Бодит геологийн нөөц			Боломжит геологийн нөөц		
	Тонн (мян.т)	Агуулга г/т Au	Унц (мян.унц)	Тонн (мян.т)	Агуулга г/т Au	Унц (мян.унц)
Исэлдсэн	578	3.0	56.2	75	1.1	2.7
Шилжилтийн	99	1.5	4.8	109	1.2	4.1
Анхдагч	5	4.9	0.7	-	-	-
Нийт	682	2.8	61.7	184	1.2	6.8

Тэмдэглэл:

1. Геологийн нөөцийн тооцооллыг Австралийн газар зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, RPM Global компанийн ажилтан Бат-Очирын Оюунбат ("Oyunbat Bat-Ochir") боловсруулж баталгаажуулсан. Оюунбат нь ордын эрдэсжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
2. Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцооллууд нь 2022 оны 11-р сарын 1-ны өдрийн тооцоолол юм. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээрх өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймлосон болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
3. Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
4. Геологийн нөөцийн захын агуулгыг исэлдсэн болон шилжилтийн хүдрийн хувьд 0.35 г/т, анхдагч хүдрийн хүрээнд 1.02 г/т байхаар тооцоолсон. Эдгээр захын агуулгын тооцоог RPM-ийн дотоод захын агуулгын тооцоолуураар тодорхойлсон бөгөөд үүнд хүдрийн 5%-ийн алдагдал 10%-ийн бохирдол ба алтны үнийг нэг унц нь US\$1,723 байхаар тооцоолсон. Мөн олборлолтын зардал нэг тонн тутамд US\$3, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, тээрэм болон боловсруулалтын хувь хэмжээ нь исэлдсэн хүдрийн хувьд 90%, шилжилтийн хүдрийн хувьд 87%, анхдагч хүдрийн хувьд 30% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан. Нөөцийн тайланд уурхайн оновчилсон хязгаарыг алтны үнэ \$2,000 ам.доллараар төсөөлсөн нь урт хугацааны урьдчилан таамагласан үнээс 1.4 дахин өндөр байна.
5. Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй болно.

Баянхөндий болон Хар Морь ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоолол

Баянхөндий болон Хар Морь ордын ТЭЗҮ-д багтсан үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллыг O2 Mining Limited-ийн захирал, мэргэшсэн этгээд Жулиен Лауренс NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартад ("NI 43-101") нийцүүлэн боловсруулсан. Баянхөндий ордын нийт үйлдвэрлэлийн нөөц, Хар Морин Дэл ордын үйлдвэрлэлийн нөөц тус бүрийг дор харуулав. Үйлдвэрлэлийн нөөц ("Mineral Reserve") нь энэхүү УХДШ-д тусгасан шинэчилсэн геологийн нөөц ("Mineral Resource")-д үндэслэсэн. Баянхөндий болон Хар Морийн үйлдвэрлэлийн нөөц нь баттай болон бодит ("Measured and Indicated") геологийн нөөцөд үндэслэсэн ба 2023 оны 8 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Нөөцийг боловсруулахдаа O2 Mining компани нь ТЭЗҮ-ийн түвшний ил уурхайн инженерийн загварчлал болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны үзүүлэлт дээр тулгуурласан.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоололд захын агуулгыг нэг унц алтны ханш \$1,816 байхад тулгуурлан, Баянхөндий ордын хувьд 0.63 г/т алт, Хар Морь ордын хувьд 0.68 г/т алтны агуулгаар тооцоолсон. Уурхайн блок загварт тодорхойлсноор эрдсийн алдагдал 2.5%, дундаж дотоод бохирдол 10% байна.

Доор танилцуулсан Баянхөндий болон Хар Морь ордын үйлдвэрлэлийн нөөцийн тайлан 2023 оны 08-р сарын 01-ний өдрөөр хүчин төгөлдөр болсон.

Баянхөндий алтны орд – Үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллын хураангуй

Ангилал	Тонн (мян.т)	Агуулга (г/т Au)	Агуулсан Au (мян.унц)	Агуулга (г/т Ag)	Агуулсан Ag (мян.унц)
Батлагдсан	2.7	4.1	360.2	1.8	159.4
Магадалсан	1.1	3.0	104.7	1.7	61.1
Нийт	3.8	3.8	464.9	1.8	220.5

Хар Морь алтны орд – Үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллын хураангуй

Ангилал	Тонн (мян.т)	Агуулга (г/т Au)	Агуулсан Au (мян.унц)
Батлагдсан	-	-	-
Магадалсан	0.2	7.0	48.8
Нийт	0.2	7.0	48.8

Тэмдэглэл:

1. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо 2023 оны 8 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон бөгөөд O2 Mining Limited компанийн Жулиен Лауренс нь мэргэжсэн этгээд;
2. Ашигт малтмалын нөөцийн тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны хүрээлэнгийн (СІМ) Тодорхойлолтын Стандарт (2014 СІМ Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны СІМ Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн;
3. Нөөцийг ил уурхайн аргаар олборлохоор тооцоолсон;
4. Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон;
5. Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,816 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн;
6. Үйлдвэрлэлийн нөөцийг хорогдуулсан олборлолтын блок моделд суурилж боловсруулсан бөгөөд 10%-ын дундаж хорогдол болон 2.5%-ын алдагдалтай байхаар тооцсон.

2023 оны ТЭЗҮ-д овоолгын хүдрийн материалыг боловсруулахдаа уламжлалт буюу бутлан, тээрэмдэж, баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. 360Global нь боловсруулах үйлдвэрийн загварчлалыг Blue Coast Research-ийн боловсруулалтын үзүүлэлтийн оновчлол зэрэг судалгаанд тулгуурлан тодорхойлсон. Энэхүү оновчлолд 60 микронд хүргэн 80% хүртэл бутлах, нунтаглах мөчлөгийн өгөгдлийн загварчлал, баяжуулах мөчлөгийн бага цианидийн баяжуулалт (0.5 г/л натрийн цианид); 36 цагийн хадгалалт, нүүрсэнд шингээх үзүүлэлтүүд, хоргүйжүүлэх урвалжийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд багтсан. Боловсруулах мөчлөг нь усны нөхөн сэргээлтийг хамгийн өндөр түвшинд байлгах, усгүйжүүлэх үйл явцыг хамгийн үр дүнтэй буюу хаягдлын чийгшлийг 15%-д байлгах, химийн болон урвалжийн хэмжээг бууруулж, байгаль орчны нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахар төлөвлөсөн.

Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баянхөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,935 тонн хүдэр, жилд 650,000 тонн хүдэр боловсруулна. Уурхайн ашиглалтын хугацаанд 4.0 г/т дундаж агуулга бүхий нийт 4.0 сая тонн хүдрийг боловсруулна. Төслийн хугацаанд металл авалт 92.6% байх бөгөөд Баянхөндий ордоос нийт 476,001 унц алт үйлдвэрлэнэ.

Үйл ажиллагааны зардлыг дээр дурдсан олборлолтын болон боловсруулалтын хувилбарууд дээр үндэслэн, эзэмшигч олборлолтыг гүйцэтгэхээр төсөөлсөн. Үйл ажиллагааны хүрээнд уурхайн эрчим хүчийг дизель болон нарны эрчим хүч хослуулсан эрчим хүч худалдан авах гэрээний дагуу хангана. Бусад зардлуудыг компани хариуцан ажиллана. Баянхөндий төслийн хувьд нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг \$869 ам.доллар байхаар тооцоолсон.

Үйл ажиллагааны зардал

	УАХ (сая ам.дол)	Ам.дол/унц	Ам.дол/тонн
Олборлолтын зардал	165	347	41
Боловсруулалтын зардал	166	349	41
Ерөнхий ба захиргааны зардал	20	43	5
Нийт үйл ажиллагааны зардал	352	739	88
Нөөц ашигласны төлбөр & бусад зардал	51	108	13
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт ба уурхайн хаалтын зардал	10	22	3
Алт үйлдвэрлэх нэгжийн өртөг	414	869	103

Тэмдэглэл: Бүхэл тоогоор тоймолсон дүн нь тооцооллын зөрүү үүсгэх боломжтой

Хөрөнгийн зардал

Уурхай байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг 88 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Боловсруулалтын өмнөх зардал, эхний дүүргэлт, талбайн хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зардал нь 2 сая ам.доллар болохоор тооцоолсон. Үүнд нэмэлтээр хөрөнгийн зардлын тооцоонд 12% буюу 10 сая ам.долларын болзошгүй зардлыг шингээсэн, нийт анхан шатны хөрөнгийн зардлыг 100 сая ам.доллараар тооцоолсон. Тогтвортой хөрөнгө оруулалтад 4 сая ам.доллар, үлдэгдэл өртгийг багтаасан хаалтын зардалд 5 сая ам.долларыг тусгасан. Баянхөндий алтны төслийн ашиглалтын хугацааны нийт хөрөнгийн зардлыг 109 сая ам.доллар хэмээн тооцов. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар ойролцоогоор 83 сая долларын зардал гарсан. Эрдэнэ Монгол ХХК-ийн удирдлагууд төслийн инженер, худалдан авалт, барилгын ("ЕРС") цогц гэрээлэгчтэй хамтран анхан шатны хөрөнгийн зардал 15%-иар нэмэгдэх магадлалтайг тооцоолсон. Гэвч одоогийн санхүүжилт нь бүтээн байгуулалтыг эцэслэх, ашиглалтад оруулахад хангалттай гэж үзэж байна.

	сая ам.дол
Боловсруулах үйлдвэр	47
Үйлдвэрээс бусад дэд бүтэц	14
Барилга байгууламжийн шууд бус зардал	27
Бүтээн байгуулалтын зардал	88
Олборлолтын өмнөх зардал	2
Болзошгүй зардал	10
Нийт боловсруулах үйлдвэр ба дэд бүтэц	100
Тогтвортой хөрөнгө оруулалт	4
Нөхөн сэргээлт ба уурхайн хаалт	7
Үлдэгдэл өртөг	(2)
Нийт	109

Тэмдэглэл: Бүхэл тоогоор тоймолсон дүн нь тооцооллын зөрүү үүсгэх боломжтой

Уурхайн төлөвлөлт – Хүдрийн хяналтын өрөмдлөг

Баянхөндийн нарийвчилсан уурхайн төлөвлөлтийг уулын ажлаас өмнө, 2025 оны 2-р улиралд боловсруулахаар төлөвлөсөн. 2024 оны 3-р улиралд 2500 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэсэн ба үүнд 1050 метрийн гүехэн өрөмдлөгийг олборлолтын эхний саруудад олборлох бүсүүдэд гүйцэтгэн, 450 метрийн илүү гүн өрөмдлөгийг өнөөгийн нөөцийн загварчлалд багтах бүсэд гүйцэтгэн, 950 метрийн өрөмдлөгийг Баянхөндийн төлөвлөсөн уурхайн хязгаарын баруун, хойд хэсэгт тэлэх боломжийг судлан гүйцэтгэсэн.

Газрын дөт гүнд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөр нь гадаргаас 15 метрийн гүн бүсүүдэд буюу олборлолтын эхний 3-4 саруудад олборлох Зүүн өмнөд Мидфийлд, Страйкер болон Өмнөд Страйкер талбайн өндөр агуулга бүхий бүсүүдэд төвлөрсөн. Үр дүнгүүдээр өнөөгийн блок загварчлал дахь өндөр агуулга бүхий бүсүүдийг баталгаажуулсан ба онцлох үр дүнгүүдэд:

- 30370: 9.52 г/т алтны агуулга бүхий 6 метр, үүнд цооногийн 4 метрээс эхлэн 50.70 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаж байна.
- 31474: 21.87 г/т алтны агуулга бүхий 5 метр, үүнд цооногийн 1 метрээс эхлэн 49.35 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал багтаж байна.
- 31695: 70.61 г/т алтны агуулга бүхий 3 метр, үүнд цооногийн 3 метрээс эхлэн 105.85 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал багтаж байна.
- 23046: 6.61 г/т алтны агуулга бүхий 12 метр, үүнд гадаргаас эхлэн 11.21 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал багтаж байна.
- 23266: 3.68 г/т алтны агуулга бүхий 13 метр, үүнд цооногийн 1 метрээс эхлэн 14.90г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал багтаж байна.

Баянхөндийн төлөвлөсөн ил уурхайн баруун, хойд бүсэд газрын дөт гүн дэх нөөцийг тэлэх боломжийг судлах 950 метрийн 6 цооног өрөмдсөн. Дээрх бүх цооногууд алтны хүдэржилтийг огтолж, нөөцийг нэмэгдүүлэх, уурхайн хязгаарыг тэлэх боломжийг харууллаа. Онцлох үр дүнгүүдэд:


- VKD-377: 7.3 г/т алтны агуулга бүхий 42 метр, үүнд цооногийн 106 метрээс эхлэн 35.8 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал багтаж байна.
- VKD-378: 6.1 г/т алтны агуулга бүхий 22 метр, үүнд цооногийн 178 метрээс эхлэн 106.8 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаж байна.
- VKD-376: Цооногийн 95 метрээс эхлэн 12.3 г/т алтны агуулга бүхий 2 метр интервал багтаасан 0.85 г/т алтны агуулга бүхий 50 метр.
- VKD-381: Цооногийн 56 метрээс эхлэн 4.1 г/т алтны агуулга бүхий 54 метр огтолсон ба үүнд 16.9, 56.8, 78.1, ба 11.1 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервалууд багтаж байна.

2024 оны 4-р улиралд Эрдэнэ Монгол нь хүдрийн хяналтын өрөмдлөгийн хөтөлбөрийн 2-р үе шатыг амжилттай хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөр нь олборлолтын эхний дөрвөн сард олборлох, газрын дөт гүнд буюу гадаргаас 15 метр гүнд байрлалтай хүдэржсэн бүсүүдийг шалгахад чиглэсэн. Хөтөлбөрийн хүрээнд 1168 метрийн 106 баганат өрөмдлөгийн цооног, 12273 метрийн 812 урвуу үлээлгэт хийн цохилтот эргэлтэт өрөмдлөгийн цооног өрөмдсөн. Үр дүн нь өмнө тодорхойлсон блок загварчлалтай тохирч байгаа ба 10 бүсэд өрөмдсөн цооногт хүдэржилт огтолж, хүдрийн блокыг тэлэх боломжтойг харуулсан. Шинээр илэрсэн эдгээр бүсийг баталгаажуулах зорилгоор 100 гаруй нэмэлт цооног өрөмдөхөөр төлөвлөж байна. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох үр дүнг доор дурдсан бөгөөд

илүү дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээний хавсралтад мэдээлсэн.

- ВКGC-827: 79.8 г/т алтны агуулга бүхий 10 метр, үүнд цооногийн 2 метрээс эхлэн 770.0 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаж байна.
- ВКGC-537: 27.8 г/т алтны агуулга бүхий 20 метр, үүнд 173.0 г/т алтны агуулга бүхий 2 метр, 91.1 г/т алтны агуулга бүхий 2 метр интервалууд багтаж байна.
- ВКGC-286: цооногийн 11 метрээс эхлэн 115.1 г/т алтны агуулга бүхий 4 метр интервал багтаж байна.
- ВКGC-58: 59.5 г/т алтны агуулга бүхий 7 метр, үүнд цооногийн 5 метрээс эхлэн 101.0 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал багтаж байна.
- ВКGC-892: 37.3 г/т алтны агуулга бүхий 8 метр, үүнд газрын гадаргаас эхлэн 144.7 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал багтаж байна.

Доорх зурагт хүдрийн хяналтын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгүүдийг харуулж, гүехэн өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд нэг болон түүнээс дээш метрийн (нийт цооногийн ~75%) 0.30 г/т алтны агуулгаас дээш (нөөцийн төлөвлөсөн захын агуулга) цооногуудыг харуулсан. Илүү өндөр агуулга бүхий интервал агуулсан цооногуудыг (20 грам-метрээс илүү, нийт цооногийн 12%) улаанаар дүрслэв. Энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээний хавсралтаас дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.



*Агуулгын хяналтын өрөмдлөгийн цооногийн байршлуудыг тодорхойлох зүүн болон хойд чиглэлийн координатуудад WGS 84 Zone 47N дата ашигласан.

** Дийлэнх цооногуудыг -60 уналт, 030 азимутаар өрөмдсөн. Ордын геологийн хэлбэлзлийн улмаас мэдээлсэн бүх интервалыг цооногийн жинхэнэ зузааны 80-100% гэж тайлбарлаж болно.

Хүдрийн хяналтын өрөмдлөгийн үр дүнг ирэх саруудад шинэчлэх Баянхөндийн уурхайн төлөвлөгөөнд тусгана. Шинэчилсэн төлөвлөгөөнд алтны үнийн өсөлтийн нөлөөллийг тусгахаар төлөвлөж байна. Өнөөгийн уурхайг алтны үнэ нэг унц нь US\$1850, уурхайн хязгаарлах хүчин зүйлийг алтны үнэ нэг унц нь US\$2000 байхаар тодорхойлсон. Алтны үнэ нэг унц нь US\$3,000 хүрч буй энэ үед уурхайн хязгаартай ойр орших нэмэлт нөөцийг уурхайн шинэчилсэн төлөвлөгөөнд багтаах боломжтой.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул

Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 20 гаруй жил хайгуул, судалгаа хийсний дүнд Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий Эрдсийн Дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг багтаадаг. Компани нь Баянхөндий төслөөс гадна алт-зэсийн ордуудыг агуулах боломжтой Хөндий-Улаан трендийн дагуу хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон.

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай болон Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын бүсийг агуулан, 4000 гаруй га талбайг хамран оршдог бөгөөд хувирлын бүс нь Улаан талбайгаас зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Дээрх

хувирлын тренд нь Баянхөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг. Энэхүү зүүн өмнөд трендийн дагуу хувирсан бүсэд Улаан, Баянхөндий болон Хар Морь зэрэг бусад эрдэсжсэн хэтийн төлөв бүхий талбай багтаж байгаа нь зүүн өмнөд трендийн хагарлын дагуу бүс нутгийн структурын тэлэлтийн тэгш бус байдал ба томоохон галт уул - плутоник төвтэй холбогддог. Хөндий-Улаан талбай дахь хэтийн төлөв бүхий болон зэргэлдээ орших бүсүүдийн хүдэржилт, хувирлууд нь томоохон структурын дагуу давхцаж эсвэл сунаж хүдэржсэн нуман шилжилт бүхий баялаг магмын арлын нуман хувиралтай уялддаг.

Өнөөдрийг хүртэл хийсэн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүнгээс харахад Хөндий-Улаан хувирлын систем болон алтны илрэлүүд илэрсэн энэхүү том алт агуулагч гидротермаль систем нь бүрэн судлагдаагүй хэвээр байна. Өнөөг хүртэл тогтоогдсон алтны хүдэржилт нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын системийн хязгаарын дагуу тэлсэн цагаан гялтгануур ба цахиураар хувирсан туфын үед байрлаж байна. Кварцын судал, шаврын хувирлын бүтцээс харахад Хөндий-Улаан системд томоохон эпитеpmаль хэв шинжийн алтны хүдэржилтийг агуулж, туфын литологи нь алтны хүдэржилтийг бүрдүүлэх таатай орчныг бий болгож ээ. Одоогоор Хөндий-Улаан талбайд хэд хэдэн геологи, геохими болон геофизикийн бүсүүдийг шалгах хайгуулын төлөвлөгөөг боловсруулж байна.

Бүс нутгийн ерөмдлөгийн хөтөлбөрийн дундаж гүнийг 100 метр орчим гүехэн ерөмдлөгөөр хязгаарласан бөгөөд цооногуудын 70 орчим хувь нь аномаль алтны хүдэржилт (>0.1 г/т алт) огтолсон. Өмнө нь орчин үеийн хайгуул хийгээгүй бүс нутагт газрын дөт гүнд геохими, геофизикийн хэтийн төлөв бүхий талбайнуудыг тодорхойлсон нь амжилтад хүрэх хүчин зүйл байв. Газрын дөт гүн хэтийн төлөв бүхий талбайг судалж, газрын гадаргад ойр гурван ордыг тодорхойлсон хайгуулын амжилт нь энэхүү шинэ дүүргийн нээлтийг баталж байна.

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай нь Баянхөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн хойд хэсэгт оршдог бөгөөд 1 г/т алтны агуулгаас өндөр чөмгөн дээж, суваг малталт болон гадаргын чулуулгийн дээжлэлт бүхий хөрсний аномализм дахь алтны утгаар тодорхойлогддог (~20 км²). Хар Морь бүсийн газрын дөт гүн дэх алтны хүдэржилт нь структурын хяналттай хувирал болон өргөн бүсийг хамран палеон гадарга руу ойртон алт агуулагч шингэнийг тараан, тэжээгч структуртай холбогдож байна хэмээн үздэг. Компани нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Хар Морь талбайд одоогийн байдлаар нийт босоо тэнхлэгийн дагуу 8-аас 318 метрт 25,132 тууш метрийн 236 цооног өрөмдсөн.

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөр нь 2021 оны эхээр нээн илрүүлсэн Хар Морин Дэл бүсэд төвлөрсөн. Эрдэнэ Ресурс нь Баянхөндий ордоос хойд зүгт 2.4 км-т өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэснээр Хар Морин Дэл бүсийг илрүүлсэн. Энэхүү өрөмдлөгөөр (AAD-58) цооногийн 10 метрээс 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метр агуулсан 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон. Өнгөрсөн жилийн өрөмдлөгийн үр дүнд Хар Морин Дэл талбайд 1.5 км-ийн хувирлын тренд, алтны хүдэржилтийг тодорхойлсон бөгөөд хойд, өмнө болон гүндээ судлын дагуу нээлттэй. Анхны нээлтээс хойш Хар Морин Дэл бүсэлд хийсэн ажлуудын онцлох үр дүн:

- AAD-126: Цооногийн 10 метрээс эхлэн 5.6 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал огтолсон бөгөөд түүнд цооногийн 26 метрээс эхэлсэн 24.12 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал багтаж байна.
- AAD-137: Цооногийн 1.5 метрээс эхлэн 9.4 г/т алтны агуулга бүхий 24.5 метр огтолсонд 16.1 г/т алтны агуулга бүхий 13.5 метрийн интервал багтсан.
- AAD-138: Цооногийн 18 метрээс эхлэн 6.1 г/т алтны агуулга бүхий 25 метр огтолсонд 17.1 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал багтсан.
- AAD-177: Цооногийн 1 метрээс эхлэн 11.4 г/т алтны дундаж агуулга бүхий 23 метр огтолсонд 32.2 г/т алтны агуулга бүхий 8 метрт 59.8 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал багтаж байна.
- AAD-178: Цооногийн 11 метрээс эхлэн 42.8 г/т алтны дундаж агуулга бүхий 15 метр огтолсонд 123.5 г/т алтны агуулга бүхий 5 метрт 160.4 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал багтаж байна.
- AAD-218: Газрын гадаргаас эхлэн 20.2 г/т алтны агуулга бүхий 12 метр огтолсонд 39.6 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал багтсан.

Хар Морин Дэл орд нь анхдагч эрдэсжүүлэгч шингэнийг дамжуулагч хэмээн тайлбарладаг зүүн хойд трендийн дагуу гүнд байрлах хувирлын хагарлыг огтолж буй хойд-өмнөд тренд, шугаман структурын коридортой холбогддог. Хойд-Өмнөд структур нь Баянхөндийн өмнөд хэсгээс Хар Морийн хойд

тэлэлтийн бүс хүртэл 5 км талбайг хамардаг. Алтны хүдэржилт нь кварц, кварц-гематит судал болон штокверк бүсээр огтолсон хүчтэй хувирсан туф болон галт уулын чулуулгийн дотор оршиж байна. Хар Морин Дэлийн дөт гүн дэх исэлдсэн бүс нь газрын гадаргаас эхлэн, 1 метрээс дээш 195 г/т алтны агуулга бүхий супергенээр баяжуулсан алтны бүсүүдийг агуулан, хугарлын дагуу хэсэгчлэн гүн исэлдэн 20-60 метрийн босоо гүнд өөр өөр зузаантай оршиж байна. Өндөр агуулга бүхий исэлдсэн биет нь хойд өмнөд суналын дагуу үргэлжилж байгааг тодорхойлсон. Хүдэржилт нь судлын дагуу болон гүндээ нээлттэй ч газрын дөт гүнд ойр хүдэржилтийн хэсэг нь Баянхөндий төслийн нэг хэсэг болох Хар Морин Дэлийн нөөцийг бүрдүүлдэг.

Хар Морин Дэл бүс дэх газрын дөт гүний исэлдсэн алтны бүс нь цагаан гялтгануураар хувирсан литологи агуулагч гидротермаль брекч ба сульфид агуулсан эпитеpmаль судлын исэлдлийн үр дүн юм. Өрөмдлөгийн хязгаарлагдмал гүний судалгаагаар алт агуулагч эпитеpmаль судал түүнтэй холбоотой цагаан гялтгануур сульфид хувирлын бүсүүд нь босоо гүнд 230 метр хүртэл ажиглагдсан бөгөөд гүндээ нээлттэй. Хар Морин Дэл бүсийн газрын дөт гүн дэх алтны хүдэржилт нь структурын хяналттай хувирал болон өргөн бүсийг хамран палеон гадарга руу ойртон алт агуулагч шингэнийг тараан, тэжээгч структуртай холбогдож байна хэмээн үздэг. Эдгээр тэжээгч структур нь гүндээ зэсийн аномаль нэмэгдэж буй алтны хүдэржилтээс өмнөх үетэй холбогдон, хэд хэдэн ил гарсан үлдэгдэл кварцын литокапуудыг агуулдаг. Эдгээр литокапууд нь гүндээ магмын порфирийн эх үүсвэрээс тэжээгч бүсүүд болон хагарлын хувирлыг төлөөлж буй Хойд-Өмнөд трендийн структурын дагуу давамгайлан тархсан. Дээр танилцуулсан өндөр агуулга бүхий алт агуулагч исэлдсэн бүсүүд нь кварц литокапийн үлдэгдэл болон туфаас порфирит галт уулын задралын нэгжид байрлаж байна.

2024 оны 2-р улиралд Эрдэнэ Ресурс нь Хар Морь талбайд 4*3 км бүсэд геологийн ба геохимийн судалгаа хийсэн. Энэ нь Хар Морь өндөр агуулга бүхий суперген алтны орд болон хэд хэдэн эхэн үеийн алтны хэтийн төлөв бүхий талбайг агуулдаг хөрсөн дэх алтны геохимийн аномаль өндөр тодорхойлогддог бүс юм. Хайгуулын хөтөлбөр нь гол алт агуулагч шинж чанартай бүс нутаг болох хойд-урагш тренд бүхий Хар Морин Дэл ба зүүн-хойд тренд бүхий Алтан Сумын хагаралтай зэрэгцээ орших стурктурт төвлөрсөн. Нийт 163 чулуулгийн дээжлэлт хийсэн ба хэд хэдэн өндөр агуулга бүхий алтны хүдэржсэн бүсүүдийг тодорхойлсон. 1.8 км зүүн хойд трендийн дагуу структурын шинж чанар бүхий Алтан Сумын хагарлын хайгуулын үр дүнд 35.7 г/т алтны агуулга бүхий дээж, 50.0 г/т мөнгөний агуулгаас дээш 12 дээж, түүн дотор 100 г/т мөнгөний агуулгаас дээш хоёр дээж багтсан. Мөн аномаль хар тугалга, молибден, сурьмагийн дээжүүдийг огтолсон нь энэхүү бүс нутаг нь дундаас дээш сульфиджилт бүхий орчин байх боломжтойг харуулж байна.

Дараагийн хөтөлбөрүүдэд Хар Морь талбайд Хар Морин Дэл ордыг тэлэх, Алтан Сумын хувирлыг илүү нарийвчлан тодорхойлох болон Хар Морин Дэлтэй зүүн зүгт зэрэгцээ структурыг судлахад чиглэсэн суваг малталт, өрөмдлөгүүд багтана.

Зүүн Өмнөд Улаан

2021 оны 6-р сард Компани нь Баянхөндий ордоос баруун зүгт 300 метрт Улаан тусгай зөвшөөрлийн талбайд анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлснээр томоохон алтны шинэ нээлтийг илрүүлсэн. Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд Зүүн-Өмнөд Улаан нэртэй томоохон алтны нээлт илрүүлсэн. Хэд хэдэн цооногуудад (354 метр хүртэл) алтны хүдэржилт илэрсэн бөгөөд 200-250 метрийн талбайг хамарсан энэхүү өрөмдлөгийн дийлэнх нь хүдэржилтээр төгссөн. Зүүн Өмнөд Улаан талбайд огтолсон алтны хүдэржилт нь газрын гадаргаас ойролцоогоор 80 метрийн гүнээс эхлэх бөгөөд 4 метрийн гүнд аномаль алт (UDH-18) огтолсон нь судлын дагуу баруун, баруун хойд зүгт болон гүндээ нээлттэй байна. 156.5 г/т хүртэл алтны агуулга нь агуулагч структур болон тэжээгч бүсүүдтэй холбоотой кварц±гематитын судлууд, штокверк бүсүүдэд тохиолдоно. Өмнөд Улааны алтны хүдэржилт дэх нэвчүүлэх чадвар багатай, цахиуржсан үнслэг туф бүхий литологи нь хүдэр агуулсан уусмалыг хэсэгчлэн хязгаарласнаар хүдэржихэд илүү тохиромжтой томовтор мөхлөгтэй лапил туфуудыг хүдэр агуулагч чулуу болгосон гэж үзэж байна. Структурын хяналт нь баруун хойд чиглэлтэй төстэй, баруун өмнөд чиглэлтэй унасан судлууд нь алт агуулж байгаа бөгөөд захын структур ба/эсвэл тэжээгч сувгууд нь ихэвчлэн зүүн хойд ба хойд зүгт чиглэсэн. Алтны хүдэржилт нь голлон бага агуулгатай, мөн литологиор хэсэгчлэн хянагдсан байх ба илүү томовтор мөхлөгтэй лапилли туф-д хүдэржилт голчлон төвлөрсөн нь баруун хойд зүг рүү давхарга зүйн уналаар нарийн ширхэгтэй цахиуржсан үнслэг туф нь хүдрийн уусмалыг нэвчүүлэх чадвар сул байдагтай холбоотой.

Анхны нээлтээс хойш Улаан тусгай зөвшөөрлийн зүүн өмнө талбайд хийсэн ажлуудын онцлох үр дүн:

- UDH-14 цооногийн 188 метрээс эхлэн 1.07 г/т алтны агуулга бүхий 217 метр интервал огтолсон нь 3.55 г/т алтны агуулга бүхий 53 метрийн интервал агуулсан.

- UDH-21 цооногийн 115 метрээс эхлэн 3.19 г/т алтны агуулга бүхий 77 метр огтолсон нь 8.74 г/т алтны агуулга бүхий 27 метрийн интервал агуулж байна.
- UDH-22 цооногийн 85 метрээс эхлэн 3.11 г/т алтны агуулга бүхий 65 метрийн интервал агуулсан 1.71 г/т алтны агуулга бүхий 152 метр огтолсон.
- UDH-35: цооногийн 187 метрээс эхлэн 13.7 г/т алтны агуулга бүхий 23 метр багтаасан 8.1 г/т алтны агуулга бүхий 41 метрийн интервал огтолсон.
- UDH-36 цооногийн 72 метрээс эхлэн 1.2 г/т алтны агуулга бүхий 179 метр интервал огтолсон. Үүнд 10-33 г/т алтны өндөр агуулга бүхий хэд хэдэн 1 метрийн интервалууд огтолж, 350 метрт хүдэржилтээр төгссөн.
- UDH-53 цооногийн 248 метрээс 24.9 г/т алтны агуулга бүхий 2 метр багтаасан 3.47 г/т алтны агуулга бүхий 27 метрийн интервал огтолсон

Баянхөндий орд, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай, Зүүн-Өмнөд Улаан талбайд хийсэн өрөмдлөгийн үр дүн нь Улаан талбайгаас зүүн хойд зүгт Хөндий тусгай зөвшөөрөл хүртэл 10 гаруй км үргэлжилдэг 4000 га талбайг хамрах Хөндий-Улаан гидротермаль системийн хүдэржилтийн цар хүрээг харуулж байна.

Төв болон хойд Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадарга дээр 5км x 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирийн хэтийн төлөвтэй талбай хэмээн ойлгогддог. Улаан талбайд гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн хуримтлал бүхий гажил байгааг тогтоосон. Мөн геофизикийн судалгаа хийж цаашид үргэлжлүүлэн судлах хэд хэдэн хэтийн төлөвт бүсийг дараагийн өрөмдлөгийн бүсээр тогтоосон.

Алтан Нар

Алтан Нар орд нь Баянхөндий ордоос баруун хойд зүгт 16 км-т орших Эрдэнэ Монгол ХХК-ийн Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн 4669 га талбайд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 3-р сарын 5 өдөр АМГТГ-аас авсан бөгөөд нийт 30 жилийн хугацаатай, нэмж 20 жилээр хоёр удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлийн талбай нь 5.6 x 1.5 км эрдэсжсэн бүс бөгөөд энэхүү бүсэд 18 (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөвт хайгуулын талбайг тодорхойлсон. Анхны хоёр нээлт болох “Нээлтийн бүс” (“НБ”), “Хойд Холбоо” (“ХХ”) бүсүүд нь Эрдэнэ Ресурсийн 2018 оны 2-р улиралд танилцуулсан нөөцийн шинэчилсэн тайлан дахь хамгийн их судлагдсан, газрын дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг агуулдаг.

Алтан Нар нь карбонат-полиметаллт алтны (“СВМГ”) орд гэж үзэж байгаа ба Карбонат-полиметаллт алтны орд нь эпитеpmаль ордын дэд бүлэгт хамаардаг ба Баррик Гоулдын Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонези), Лундинын Фрута Дел Норте (Эквадор), Континентал Гоулдын Буритика төсөл (Колумби) зэрэг ордууд нь энэ төрөлд багтдаг. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба хүдэржилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.

Өнгөрсөн жилүүдэд Компани нь Баянхөндий төсөлд төвлөрөн ажилласан тул Алтан Нар төслийн талбайд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн. Нээлтийн бүсэд 2019 оны 4-р улиралд нийт 667 тууш метр өрөмдлөгийн судалгаа хийсэн. Нээлтийн бүсэд урьд нь өрөмдлөг хийж байгаагүй 70 метр талбайд (“Gar Zone”) өндөр агуулга бүхий цөмийг судлахаар 130 метрийн гүн дөрвөн цооног өрөмдсөн. Ордыг өмнө зүгт тэлэх боломжтой талбайг тав дахь цооногоор шалгасан. 2019 оны хайгуулын хөтөлбөрийн үр дүнгээр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135) нь өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүнд тооцогдож байна. 2019 оны үр дүнгүүд нь урьд нь бага агуулга бүхий нөөцийн блокуудын гадна оршиж, Нээлтийн бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлж, өндөр агуулга бүхий хүдэржилт тууштай үргэлжилж буйг харуулсан. Өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн нь Алтан Нарын нөөцөд зөргөөр нөлөөлж, дүүргийн бусад бүсүүдэд тэлэлт хийх боломжийг нээж байна. Өрөмдлөгийн хөтөлбөр нь Нээлтийн бүсийн өмнө зүгийн дагуу структурын коридорын дагуу аномаль алт, суурь металл тууштай үргэлжилж буйг харуулсан. Ирээдүйн хөтөлбөрүүдээр үргэлжлүүлэн судална.

Өнөөг хүртэл, Нээлтийн бүс ба Хойд Холбоо талбайд бодитой нөөц тодорхойлогдсон. Алтан Нарын үлдсэн 16 хэтийн төлөв бүхий талбайд Компани үргэлжлүүлэн хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлж, эрдэсжсэн системийн ойлголтыг бататгахаар төлөвлөсөн. RPMGlobal нь 2018 оны 5 сард Алтан Нарын эрдсийн нөөцийн тооцооллыг танилцуулахдаа хэд хэдэн захын агуулгыг тооцсон бөгөөд RPMGlobal Баянхөндийн ил уурхайн нөөцийг 0.7 г/т алттай дүйцэх нэгж2 (Доорх тэмдэглэлийн 8 дахь зүйлтэй танилцана уу) харин ил уурхайгаас доош гүнд орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор

тооцоолохыг зөвлөсөн. Алтан Нар алт-полиметаллын төслийн геологийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг 2021 оны 3-р сарын 29-нд танилцуулсан Алтан Нар алтполиметаллын төслийн NI 43-101 техникийн тайлангаас авч танилцана уу.

Захын агуулга AuEq2 г/т	Нөөцийн агуулга	Тоо хэмжээ (сая.т)	Агуулга					Агуулсан металл				
			Au г/т	Ag г/т	Zn г/т	Pb г/т	AuEq2 г/т	Au Koz	Ag Koz	Zn Kt	Pb Kt	AuEq2 Koz
0.7	Бодитой	5.0	2.0	14.8	0.6	0.6	2.8	318	2,350	31.6	29.0	453
	Боломжтой	3.4	1.7	7.9	0.7	0.7	2.5	186	866	23.7	22.3	277

Тэмдэглэл:

- (1) Ил уурхайн нөөцийт 0.7 г/т, ил уурхайгаас гүнд буй нөөцийн захын агуулгыг 1.4 г/т AuEq байхаар тоо.
- (2) Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жерми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын хүдэржилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- (3) Нөөцийн тайлангийн талаар дээрх хүснэгтэд багтсан мэдээлэл нь 2018 оны 5-р сарын 7 хүртэл хийгдсэн өрмийн судалгааны үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай
- (4) Тайланд тусгагдсан нөөцийн агуулга нь CIM стандартын дагуу тайлагнагдсан
- (5) Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- (6) Нөөцийн тайланд бохирдол болон хүдрийн алдагдлын хүчин зүйлсийг багтаагаагүй.
- (7) Олборлолт хийгдэх болсон тохиолдолд металл авалтын алдагдал гарах магадлалтай.
- (8) AuEq буюу алттай дүйцэх нэгж2 нь алтыг нэг унц US\$1,310, мөнгийг нэг унц US\$18, хар тугалга нэг тонныг US\$2,400 цайрыг нэг тонныг US\$3,100 байхаар тооцоолсон.

Алтан Нар ордын дэлгэрэнгүй мэдээллийг SEDAR-т байршуулсан бөгөөд "Altan Nar Gold-Polymetallic Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia, National Instrument 43-101 Technical Report" нэртэйгээр 2021 оны 3-р сарын 29-нд бүртгүүлсэн.

Зуун Мод молибден-зэсийн төсөл

Зуун Мод нь Монголын баруун өмнөд хэсэгт оршдог молибден-зэсийн порфирийн орд юм. Улаанбаатар хотоос баруун урд зүгт ойролцоогоор 950 км, Монгол-БНХАУ-ын хил Сэхээ боомтоос 215 км зайд байрладаг. Төсөл нь нийт 6041 га талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Компанийн охин компани Аниан Ресорсиз ХХК-ийн эзэмшилд байдаг ба ашиглалтын тусгай зөвшөөрөл нь эхний 30 жилийн хугацаанд явж байна. Энэ төслийг Галлант Минералз Лимитэд компаниас 2005 онд авсан бөгөөд Галлант Минералз компанид буцаан худалдаж авах боломжтой 1.5%-ийн нөөцийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн.

Компани нь 2011 онд NI 43-101 стандартын дагуу Зуун Модын нөөцийг тооцоолон олон нийтэд танилцуулсан. Захын агуулгыг 0.04% молибден гэж тооцон, дунджаар 0.057% молибден болон 0.069% зэсийн агуулгатай 218 сая тонн ("сая тн") баталгаатай ба бодит нөөц тооцоолсон. Энэ нь молибденийн 273.5 сая фунт болон зэсийн 330.7 сая фунттэй тэнцэнэ. Үүнээс гадна, Зуун Модод дунджаар 0.052% молибден болон 0.065% зэсийн агуулгатай 168 сая тонн таамаг нөөц байгаа ба энэ нь молибден агуулсан 191.8 сая фунт болон зэс агуулсан 240.5 сая фунт байна.

2023 онд Зуун Мод төслийн талбайд 4100 тууш метрийн 12 цооног өрөмдсөн. Ордын төв хэсэгт (ZMD-131 цооног) өндөр агуулга бүхий хүдэржилт үргэлжилж буйг шалгах болон бодитой нөөцийн бүсийн зэргэлдээ (ZMD-132-с 135 цооног) үргэлжлэлийг тэлэх зорилтын хүрээнд нийт 2476 тууш метрийн 5 цооног өрөмдсөн. Түүнээс гадна, Зуун Мод порфирийн системийн хүрээнд 1619 тууш метр 7 цооног (ZMD-136 to 142) өрөмдөв.

ZMD-131 цооногт 0.140% Мо ба 0.121% Си агуулсан 29 метрийн интервал (252-с 280 метр) багтаасан 0.080% Мо дундаж агуулга бүхий хэд хэдэн бүсийг (28-с 74 метрийн өргөн) огтолсон ба эдгээр бүсүүд нь 0.053% Мо ба 0.072% Си дундаж агуулга бүхий 374 метрт багтаж байна. Зуун Модын бодитой нөөцийн бүсийн (ZMD-132-135 цооног) хязгаар дагуу өрөмдсөн дөрвөн цооног нь 40-187 метрийн зузаан (>0.04% Мо) нөөцийн зэрэглэлийн хүдэржилт огтолсон. Зуун Мод порфирийн цогцолборын хойд бүсэд өрөмдсөн хэд хэдэн хайгуулын цооногуудад (ZMD -140-142 цооног) аномаль зэсийн хүдэржилт (0.05% Си-ээс дээш) илэрсэн. Төв ордын бүсээс баруун зүгт 1 км-т зүүнээс баруун тийш 600 метр хамарсан талбайд гурван цооног өрөмдсөнд аномаль молбиден, зэс ба мөнгөний утга илэрсэн. Хайгуулын цооног болох молибденийн хүдрийн биетээс хойд зүгт 1.7 км-т өрөмдсөн ZMD-139 цооногт (одоогоор ZMD-135 цооногоор тодорхойлогдож буй) их хэмжээний молибденийн хүдэржилт огтолсон нь (0.067% Мо бүхий 12 метр) Зуун Мод порфирийн цогцолборт нийтлэг тохиолддог порфирит гранодиорит агуулсан. Одоогоор Зуун Мод орд болон энэхүү цооногийн

хооронд өрөмдлөг хийгдээгүй бөгөөд ирээдүйд томоохон талбайд эрдэсжилт нээх боломжийг бий болголоо.

Молибден-зэсийн порфирийн ордоос гадна, тусгай зөвшөөрлийн талбай нь Зуун Мод ордоос хойд зүгт ойролцоогоор 2.2 км-т орших зэс-мөнгөний томоохон хэтийн төлөв бүхий талбайг агуулдаг. Тус хэтийн төлөв бүхий талбайн хайгуулын ажилд геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хол алслагдтай өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилтай цэг шалгах өрөмдлөгийн судалгаагаар 308-342 метр гүнд 1.3% зэс болон 9.24 г/т мөнгөний агуулгатай 34 метрийн интервал (ZMD-121) огтолсон. Нэмэлтээр хийсэн өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-аас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалуудыг (12-42 метр) огтолсон.

2024 оны 2-р улиралд тусгай зөвшөөрлийн талбайд Зуун Мод молибден-зэсийн ордын баруун зүгт 4.5 км-т шинэ алтны хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Гадаргын дээжлэлтээр 3.2 г/т алтны агуулга бүхий хүдэржилтийг илрүүлсэн нь төмрийн ислийн штокверк ба хэд хэдэн огцом налуу зүүн-баруун трендийн дагуу бүрхэгдсэн кварцын судалд багтаж байна. Хүдэржсэн кварцын судал нь 20 см хүртэл зузаан ба судлын дагуу 500 метрийг хамарч байна. Шинээр нээн илрүүлсэн алтны хэтийн төлөв бүхий талбай нь 500*500 метрийг хамарч байгаа боловч бүрхэгдсэн судал нь бүх зүгт нээлттэй тул тэлэх боломжтой. 2-р улиралд нийт 31 дээжид судалгаа хийсэн бөгөөд 20 дээжид аномаль алт илэрсэн.

Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрөлд илрүүлсэн хамгийн өндөр алтны агуулгыг шинэ хэтийн төлөв бүхий талбайгаас илрүүлсэн ба энэ нь зүүн зүгт молибден-зэсийн порфир тодорхойлогдсоноос баруун зүг рүү алтаар баялаг шинж чанар луу шилжсэн геохимийн шилжилт байх боломжтой. Энэ жил нарийвчилсан зураглал, геофизикийн судалгаа болон суваг малталтын ажлуудыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөсөн. Мөн Зуун Мод ордыг тэлэх зорилгоор 10000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг төлөвлөсөн ба нарийвчилсан хугацааг ирээдүйд тодорхойлно.

Зуун Мод ордын нөөцийн тайланг SEDAR-т байршуулсан бөгөөд "Technical Report Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, South-Western Mongolia, National Instrument 43-101 Independent Technical Report" нэртэйгээр 2011 оны 6-р сард бүртгүүлсэн.

Хөрөнгө оруулалт

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хайгуулын тусгай зөвшөөрлийг олгодог. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөвтэй талбайнуудыг тодорхойлсон. Энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна. Түүнээс гадна хувийн өмчийн хуулийн этгээдүүдтэй хэлцэл хийх замаар тусгай зөвшөөрлийн талбайг эзэмших боломжуудыг судалсаар байна. Монгол Улсад урт хугацаанд ажилласан туршлагатай хайгуулын компанийн хувьд үнэт болон суурь металлын хүрээнд цаашид тэлэх боломжуудыг судална.

Санхүүгийн тайлангийн онцлох мэдээлэл

Доорх санхүүгийн мэдээлэлд 2022, 2023, 2024 оны 12 сарын 31-ний байдлаар аудитлагдсан, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг тусгав (Үнэт цаасны тоо хэмжээнээс бусад нь мян.канад доллараар илэрхийлэгдсэн):

12 сарын 31-нд дуусгавар болсон	2024	2023	2022
Орлого	Nil	Nil	Nil
Алдагдал	\$ 8,246	\$ (522)	\$ 5,986
Нэгж хувьцаанд ногдох суурь ба хорогдуулсан алдагдал	\$ 0.02	\$ 0.00	\$ 0.02
Нийт хөрөнгө	\$ 63,000	\$ 59,063	\$ 52,533
Нийт урт хугацааны өр төлбөр	-	-	\$ 23

Үйл ажиллагааны хэлэлцүүлэг

2023, 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн мэдээлэл

Доорх хүснэгтэд 2023, 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлыг харуулав.

	12 сарын 31-нд дуусгавар болсон		
	2024	2023	Өөрчлөлт
Элэгдэл, хорогдол	\$ 4,227	\$ -	\$ 4,227
Шууд зардал	383,557	111,087	272,470
Ажилтнуудын урамшууллын зардал	2,046,890	71,694	1,975,196
Хувьцаанд суурилсан урамшуулал	518,129	664,229	(146,100)
Хараат компаниас нөхөн төлөгдсөн :	(1,100,161)	-	(1,100,161)
	\$ 1,852,642	\$ 847,010	\$ 1,005,632

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд хайгуул, үнэлгээний зардал \$1,852,642 байсан ба өмнөх оны мөн үед \$847,010 байв.

2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн шууд зардал 2023 оны мөн үеэс \$272,470-аар өссөн бөгөөд энэ нь өмнөх онд техникийн болон зөвлөх үйлчилгээний зардал Зуун Мод төслийн хайгуулын ажилтай холбоотой тул капиталжуулж, харин энэ онд техникийн болон зөвлөх үйлчилгээний зардлын тодорхой хэсгийг зарлагадсантай холбоотой.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд ажилтнуудын цалин урамшууллын зардал нь өнгөрсөн оны мөн үеэс өссөн нь ММС-тэй стратегийн түншлэлийг эцэслэснээр 2023 оны сүүлээс ЭМ-ээс Компанид ажилтнуудыг шилжүүлсэн, түүнчлэн, 2025 онд Баянхөндий төслийн анхны алтыг олборлох хүрээнд олгох удирдах албан тушаалтнуудын урамшууллыг энэ онд хуримтлуулж тооцсон нөлөөлөлтэй холбоотой болно.

2024 оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн хугацаанд бэлэн бус хувьцаанд суурилсан урамшуулал нь өнгөрсөн оны мөн үеэс \$146,100 бага байсан нь опционы бодит үнэ цэн багатай холбоотойгоор цөөн хэмжээний хувьцааны опцион олгосон.

Компани нь хараат компанитай геологийн үйлчилгээ үзүүсэний хүрээнд жил бүр татвар суутгасны дараах нэг сая ам.долларын нөхөн төлбөр төлөх гэрээтэй ба Эрдэнэ Монгол нь Эрдэнэ Ресурсд төлөх нөхцөлтэй.

Дараах хүснэгтээр 2023, 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацааны компанийн болон захиргааны зардлуудыг харуулав.

	12 сарын 31-нд дуусгавар болсон		өөрчлөлт
	2024	2023	
Захиргааны үйлчилгээ	\$ 1,198,872	\$ 935,025	\$ 263,847
Элэгдэл, хорогдол	25,600	36,958	(11,358)
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, зардал	114,901	122,244	(7,343)
Санхүүжилтийн зардал	1,495,147	-	1,495,147
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	487,533	318,225	169,308
Оффис ба бусад	96,865	105,686	(8,821)
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	379,827	504,095	(124,268)
Зохицуулагч байгууллагын төлбөр	90,749	109,322	(18,573)
Хувьцаанд суурилсан урамшуулал	1,054,714	902,280	152,434
Томилолтын зардал	98,850	103,900	(5,050)
	\$ 5,043,058	\$ 3,137,735	\$ 1,905,323

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон нэг жилийн хугацаанд компанийн ерөнхий болон захиргааны зардал \$5,043,058 байсан ба өмнөх оны мөн үед \$3,137,735 байв.

Компанийн ерөнхий болон захиргааны зардал нь 2024 оны 12 сарын 31-ний байдлаар өмнөх оны мөн үеэс \$263,847 доллараар өссөн нь анхны алт олборлохтой холбоотой удирдах ажилтнуудын урамшууллын хуримтлал болон амьжиргааны өртөгтэй холбогдон цалингийн зардал өссөнтэй холбоотой.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд санхүүжилтийн зардал \$1,495,147 байсан нь өмнө нь капиталжуулсан төслийн санхүүжилт, ММС-тэй байгуулсан зээлийн гэрээг эцэслэсэнтэй холбоотойгоор өмнө нь хойшлуулсан төслийн санхүүжилтийн судалгаа, шинжилгээний зардал болон стратегийн түншлэлийг эцэслэсэнтэй холбоотой хойшлуулсан зардлуудыг хассантай холбоотой.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд хөрөнгө оруулагчтай харилцах, маркетингийн зардал нь өмнөх оны мөн үеэс \$169,308-аар өссөн нь хөрөнгө оруулагчдыг төсөлтэй танилцуулах зардлын өсөлт нь социал медиа маркетингийн зардлын бууралтаас их байгаатай холбоотой.

Мэргэжлийн үйлчилгээний төлбөр нь 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд өнгөрсөн оны мөн үеэс \$124,268-оор буурсан нь хөрөнгийн зах зээлийн дэмжлэг буурсантай холбоотой.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд зохицуулагч байгууллагын төлбөр өмнөх оноос \$18,573-аар буурсан нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг биетээр бус цахим хэлбэрт шилжүүлснээр түүнтэй холбоотой зардал буурсанаас үүдсэн.

Бэлэн бус хувьцаанд суурилсан урамшуулал 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд өмнөх оны мөн үеэс \$152,434-өөр нэмэгдсэн нь ТУЗ-ийн гишүүдэд олгосон ИОХЭ-ийн тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд элэгдэл, ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, зардал, оффис болон бусад, томилолтын зардал зэрэг нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад материаллаг өөрчлөлт ороогүй.

Дөрөвдүгээр улирал

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд хайгуул болон үнэлгээний зардал \$256,993 байсан нь хайгуулын багийн цалин урамшуулал болон холбогдох зардлуудыг тусгасан. Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн нь дээрх зардлуудыг урьд нь Баянхөндий алтны төсөл рүү капиталжуулж байсантай холбоотой.

Компанийн ерөнхий болон захиргааны зардал нь 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$1,016,351 байсан нь \$300,529 долларын цалин урамшуулал, захиргааны зардлууд, \$23,019 долларын нээлттэй компанийн холбогдох зардлууд, \$226,023 долларын санхүүжилтийн зардал, \$162,946 долларын мэргэжлийн үйлчилгээний зардал, \$84,924 долларын бэлэн бус хувьцаанд суурилсан урамшуулал, \$218,910 долларын томилолт, оффис, хөрөнгө оруулагчтай харилцах зэрэг бусад захиргааны зардлуудыг багтааж байна.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын алдагдал \$1,424,837 байсан нь өмнөх оны мөн үеийн \$572,346 доллартай харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Энэ нь 2024 оны 2-р сарын санхүүжилттэй холбоотой зээлийн

нэмэгдсэн зардал нь 2024 оны 1-р улиралд стратегийн түншлэлийг эцэслэснээр хувь эзэмшилд орсон өөрчлөлтөөр хэсэгчлэн нөхөгдсөнтэй холбоотой.

Улирлын үр дүнгийн хураангуй

Нэгж хувьцаанад ногдох ашиг, алдагдлаас бусдыг мян.канад доллараар илэрхийлсэн.

	Санхүүгийн жил 2024				Санхүүгийн жил 2023			
	Q4 12 сар	Q3 9 сар	Q2 6 сар	Q1 3 сар	Q4 12 сар	Q3 9 сар	Q2 6 сар	Q1 3 сар
Алдагдал	\$2,011	\$1,688	\$1,869	\$2,678	\$1,176	\$1,200	\$2,508	(\$5,406)
Нэгж хувьцаанд ногдох алдагдал	\$0.01	\$0.00	\$0.00	\$0.01	\$0.00	\$0.01	\$0.01	(\$0.02)
Нийт хөрөнгө	\$63,000	\$55,729	\$57,189	\$57,820	\$59,063	\$60,663	\$62,478	\$64,162

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд Компани нь \$2,011,119 долларын цэвэр алдагдалтай байсан ба 2023 оны мөн үед \$1,176,204 доллар байсан.

Компанийн зардал нь Монгол дахь хайгуулын хөтөлбөрүүдээс хамаарч улирал тутамд харилцан адилгүй байдаг. Компани нь өнгөрсөн хугацаанд санхүүгийн үр дүнд нөлөөлж болохуйц мэдээ болон тодорхой чиг хандлагын тухай мэдээлэл аваагүй болно.

Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц

Энэхүү УХДШ гарах өдрөөр Компанийн бэлэн мөнгө \$6.0 сая канад доллар, эргэлтийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор \$5.4 сая канад доллар байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх (Хайгуул, хөгжүүлэлтийн төслүүд ба Үйл ажиллагааны хэлэлцүүлгээс танилцана уу), тэдгээрийг дэмжих захиргааны зардлуудыг санхүүжүүлэхэд зарцуулсан. Компани нь өөрийн хайгуулын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чадвар нь ММС-тэй хийсэн стратегийн түншлэл, зээлийн санхүүжилт, хөрөнгө борлуулалт, опцион болон хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах зэргээр тодорхойлогдоно.

Компанийн орлогын эх үүсвэр хязгаарлагдмал тул мөнгөн гүйлгээнд дүн шинжилгээ хийх эсвэл ямарваа нэг бодитой чиг хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй. Компани нь хайгуулын болон төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүдээ нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааны санхүүжилт татан төвлөрүүлэх болон зээлийн санхүүжилтээр санхүүжүүлж байна.

Энд дурдсан төлөвлөгөөт зардлаас бусдаар Компани нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, урьдчилан тооцоолж болохуйц ирээдүйн капитал хөрөнгө материаллаг байдлаар өсөх/буурах аливаа чиг хандлага, шаардлага, үүрэг, үйл явдал, тодорхой бус байдлын талаар мэдээлэл байхгүй болно.

Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй

Гаргасан ба эргэлтэд буй хувьцаат капитал

	2025.03.24	2024.12.31
Гаргасан ба эргэлтэд буй энгийн хувьцааны тоо	363,026,958	362,136,958
Опцион	24,180,000	22,445,000
ИОХЭ	9,991,248	9,991,248
Нийт гаргасан санхүүгийн хэрэгсэл	397,198,206	394,573,206

Гэрээгээр хүлээсэн үүрэг

Дараах хүснэгтэд 2024 оны 12 сарын 31-ний байдлаар Компанийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулав:

	Нийт	>1 жил	1-2 жил
Дансны өглөг ба хуримтлагдсан өр төлбөр	\$782,851	\$782,851	-
	\$782,851	\$782,851	\$ -

Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг

ММС стратегийн түншлэл

2023 оны 1-р сард Эрдэнэ Ресурс нь ММС-тэй стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан. ММС нь \$40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-тай тэнцэх хувьцааг эзэмших нөхцөлтэй гэрээ байгуулсан. Энэхүү хөрөнгө оруулалтийн нөхцөлүүдийг хангагдаж хөрвөх нөхцөлтэй хөрөнгө 2024 оны 1 сарын 23-ны өдөр эцэслэгдэн шилжсэн. Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-ийг эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн 5 км орчимд эзэмших тусгай зөвшөөрлүүд дээр 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх) авах нөхцөлтэй.

Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор 2024 оны 2-р сарын 8-ны өдөр Эрдэнэ Ресурс нь ММС-тэй төслийн санхүүжилтийн гэрээг байгуулав. Эрдэнэ Ресурс болон ММС нар нь Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК-ийг хамтран эзэмшдэг ба тус санхүүжилт нь ММС-ээс хувь эзэмшигчийн зээлийн нөхцөлөөр олгогдоно.

Баянхөндий төслийн бүтээн байгуулалтад хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр 50 сая ам.долларын санхүүжилт авсан ба энэ нь таван үе шаттайгаар, нэг удаагийн санхүүжилт 5 сая ам.доллараас багагүй байна. Зээлийн хугацаа нь олгогдсон өдрөөс таван жилийн хугацаатай ба 13.8%-ийн хүүтэй, улирал бүр төлөх төлбөрийн нөхцөлтэй. Эрдэнэ Монгол ХХК нь эхний дөрвөн хүүгийн төлбөрийг капиталжуулах боломжтой ба зээлийг хугацаа дуусахад бүрэн төлсөн байх нөхцөлтэй. Үлдсэн 30 сая ам.долларыг зээлийн адил нөхцөлтэйгөөр ММС олгох боломжтой. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар ЭМ нь 49 сая долларын хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр авсан ба хүүгийн капиталжуулалтаас үүдэн 52 сая долларын үлдэгдэл байна.

Зээлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК дахь өөрийн эзэмшлийн 50% болон Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эзэмших борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх)-ийг барьцаа хөрөнгө болгоно. Зээлийн эргэн төлөгдөх хугацаанд талуудын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээний дагуу ММС давуу эрхийн саналтай байх бөгөөд Эрдэнэ Ресурсийн Зуун Мод төслийн хувьд тэргүүн ээлжид татгалзах эрх эдэлнэ. Эрдэнэ Ресурс нь ММС-тэй адил нөхцөлөөр зээлийн 50%-ийг хувьцаа эзэмшигчийн зээл хэлбэрээр олгох боломжтой.

Баянхөндий эргэлтийн хөрөнгийн зээл

2024 оны 12 сарын 4-нд Худалдаа хөгжлийн банктай Баянхөндий төслийг ашиглалтад оруулахад эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр олгох санхүүжилтийн бичиг баримтад гарын үсэг зурсан. Энэ нь 50 сая ам.доллар хүртэл санхүүжилтийг 24 сарын хугацаатай олгох ба зээлийн эцсийн зургаан сарын хугацаанд сар бүр ижил хэмжээний эргэн төлөлт хийх нөхцөлтэй. Зээл нь жилийн 13.3%-ийн хүүтэй бөгөөд Баянхөндий төслийн боловсруулах үйлдвэрийн барилга, хөрөнгөөр баталгаажсан. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар Эрдэнэ Монгол нь 20 сая ам.долларын зээлийг хүлээн авсан.

Сэндсторм Гоулд ("Sandstorm Gold Ltd") Роялти гэрээ

Сэндсторм Гоулд Лтд. ("Sandstorm") нь Эрдэнэ Ресурсийн батламжилсан Эрдэнэ Монгол ХХК-ийн Алтан Нар, Хөндий болон Улаан тусгай зөвшөөрлүүдэд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн ("NSR") эрхийг эзэмшдэг. Сэндсторм нь Алтан Нар болон Хөндий тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн роялти санхүүжилтэд хориг тавих эрхтэй.

Бусад

Компани Зуун Мод тусгай зөвшөөрлийн борлуулалтын цэвэр ашгаас 1.5%-ийн төлбөрийг (“БЦАТ”) Версамет Роялти Корп-д өгөх нөхцөлтэй. Эрдэнэ Ресурс нь олборлолтын тодорхой шатанд хүрснээр БЦАТ-ийн тодорхой хэсгийг буцаан худалдан авах эрхтэй.

Балансаас гадуурх зохицуулалт

Компани нь 2024 оны 12 сарын 31-ний байдлаар дээр дурдсанаас гадна батлан даалтын гэрээ, бусад байгууллагад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болзошгүй үүрэг, үүсмэл хэрэгсэл буюу Компанид санхүүжилт, хөрвөх чадвар, зах зээлийн болон зээлийн эрсдэл учруулж болзошгүй аливаа үүрэг гэх мэт балансаас гадуурх аливаа зохицуулалт хийгээгүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж, тооцоолол

Санхүүгийн тайланг бэлтгэх явцад СТОУС-ын шаардлагаар Компанийн удирдлага нь тайлан болон холбогдох тодруулгуудтай холбоотойгоор материаллаг өөрчлөлт, нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалууд дэвшүүлэхийг шаарддаг. Үнэлэмж, тооцооллууд нь олон хүчин зүйлд үндэслэх бөгөөд түүхэн туршлага, одоогийн болон хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт мэдээллүүдийг ашигласан. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрөх магадлалтай.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйлсан тайлбар, дараагийн 12 сарын хугацаанд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд мэдэгдэхүйц залруулга хийхэд хүргэж болох дүгнэлт, тооцоолол, таамаглалыг 2024 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 2-т тусгасан. Дараах эх сурвалжуудыг онцолсон:

- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дахь нөлөөллийг тодорхойлох;
- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралт

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дахь нөлөөллийг тодорхойлох

Компанийн охин компаниуд дахь хувь хэмжээ нь нөлөөллийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бөгөөд ингэснээр өмчийн бүртгэлийн аргаар бүртгэнэ. Удирдлага нь хууль ёсны эзэмшлийн хувь хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн шийдвэр гаргах үйл явцад дүн шинжилгээ хийх замаар дээрх нөлөөллийг тодорхойлдог. Эрдэнэ Ресурс нь 2023 оны 1-р сарын 10-ны өдөр Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтын хувь хэмжээг шилжүүлсэн даруйдаа удирдлага нь ЭМ олборлолтод чухал нөлөө үзүүлэх боломжтой гэдгээ тодорхойлж, энэ хөрөнгө оруулалтыг хувь нийлүүлэх аргын дагуу хараат компани гэж бүртгэсэн.

Стратегийн түншлэлийг эцэслэснээр, 2024 оны 1 сарын 23-нд Эрдэнэ Монгол ХХК нь 50%-ийн хувьцааг нэмж гарган, ММС-д эзэмшүүлсэн бөгөөд удирдлага нь дүн шинжилгээг шинэчилж, Компани нь Эрдэнэ Монгол ХХК-д нөлөөлөх нөлөөлөл өндөр байгааг баталгаажуулсан. Ингэснээр өмчийн бүртгэлийн аргаар хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт хэлбэрээр бүртгэж байна.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралт:

Компани цэвэр хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрсний дараа үүссэн нэг буюу хэд хэдэн үйл явдлын үр дүнд үнэ цэний бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлэхийн тулд НББОУС 28 дагуу “Хараат аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан үйлдвэрлэл дэх хөрөнгө оруулалт”-ын удирдамжийг дагаж мөрддөг. Энэ дүгнэлтийг хийхдээ компанийн удирдлага цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралтын бодит нотолгоо, тухайлбал: хараат компанид учирч буй санхүүгийн томоохон хүндрэл, гэрээ зөрчсөн байдал, хараат компани төлбөрийн гүйлгээ хийх чадваргүй болох эсвэл хоцрох, цаашид дампуурах эрсдэл үүсэх, санхүүгийн шинэчилсэн өөрчлөн байгуулалтад орох, эсхүл хараат компанийн санхүүгийн хүндрэлийн улмаас түүнд хөрөнгө оруулах идэвхтэй зах зээл алга болох зэрэг олон хүчин зүйлийг үнэлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт

2024 оны 1 дүгээр сарын 1-ээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн.

НББОУС 1 – Санхүүгийн тайлангийн толилуулга

2022 оны 10-р сард НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт оруулан, өр төлбөрийн ангиллыг илүү ерөнхий болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах нь өр төлбөрийг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх хүлээлтээс ялгаатай нь тайлант хугацааны эцэст үүссэн эрхээс хамаарна гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төлбөр тооцоо нь харилцагч тал руу бэлэн мөнгө, өмчийн хэрэгсэл, бусад хөрөнгө болон үйлчилгээг

шилжүүлэхийг хэлнэ гэж тодотгосон. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой суурь өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

Дараах шинэ стандартууд, СТОУС-ын стандарт, тайлбарт оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь 2024 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд хүчин төгөлдөр болоогүй бөгөөд Эрдэнэ Ресурс нэгтгэсэн тайланг бэлтгэхэд ашиглаагүй болно.

НББОУС 21 –Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл

2023 онд 8 сард НББОУС нь НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөлд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь аж хуйн нэгжүүдэд валют хоорондын хөрвөх чадварыг үнэлэх, хөрвөх чадвар хангалтгүй нөхцөлд бодит ханшийг тодорхойлох аргачлалыг сайжруулахад чиглэсэн. Энэхүү өөрчлөлт нь гадаад валютаар гүйлгээ хийдэг; үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид хамаарах бөгөөд тодорхой зорилготойгоор валют хөрвүүлэх боломжгүй нөхцөлд мөн хамааралтай. Валют нь хөрвөх боломжтойд тооцогдохын тулд бусад валютыг сольж авах боломжтой (зөвшөөрөгдсөн зохицуулалтын хүрээнд ердийн хоцрогдолтой байж болно) болон зах зээл эсвэл хөрвүүлгийн механизмын хүрээнд эрх, үүргийн дагуу солих нөхцөл бүрдсэн байх шаардлагатай.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2025 оны 1 сарын 1-ний өдрөөс болон түүнээс хойш хүчин төгөлдөр мөрдөх бөгөөд энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт орохгүй. Энэ нь Компанийн гүйлгээнд ашигладаг гадаад валютын хувьд өнгөрсөн хугацаанд хөрвөх чадварын ноцтой хүндрэл үүсэж байгаагүй.

СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2024 оны 4 сарын 9-нд НББОУС3 (“IASB”) нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгыг орлуулах зорилгоор СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга танилцуулсан. СТОУС 18 нь ашиг алдагдлын тайлангийн хүрээнд ангилал, тодорхойлсон дэд нийлбэр нэмж, удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийн тодруулга, санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэх, задлахыг сайжруулах шаардлагыг тусгасан. СТОУС 18-ын хүрээнд НББОУС 7-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны орлогын дэд нийлбэрийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлагнах шууд бус аргаар эхлэл болгон ашиглах, мөн хүү, ногдол ашгийн төлбөрүүдийг төлсөн болон хүлээн авсан талаар тайлагнах хувилбаруудыг хасах шаардлагатай болсон. Үүнтэй адил НББОУС 33 Нэгж хувьцаанд ногдох ашигт нэмэлт өөрчлөлт оруулж, СТОУС 18-д нийт эсвэл дэд нийлбэрийн тоон үзүүлэлтээр ашиг, алдагдлын тайлангийн бусад бүрэлдэхүүн хэсгийг ашиглан нэгж хувьцаанд ногдох ашгийн нэмэлт мэдээллийг тодруулахыг зөвшөөрсөн. СТОУС 18 нь 2027 оны 1 сарын 1-ээс эхлэн тайлангийн үеүүдэд хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр гарах нөлөөллийг үнэлж байна.

СТОУС 7 ба 9 - Санхүүгийн хэрэглүүр болон тодруулга

2024 оны 5 сараас эхлэн НББОУС3 (“IASB”) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон үнэлгээнд (СТОУС 7 болон СТОУС 9) нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээр СТОУС 9-ийн ангилал болон үнэлгээ, СТОУС 7-ийн холбогдох тодруулгын шаардлагыг шинэчилсэн. НББОУС3-өөс зарим санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, данснаас хасах хугацааг тодруулж, цахим төлбөрийн системийг ашиглан санхүүгийн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой шаардлагад өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлт нь 2026 оны 1 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр гарах нөлөөллийг үнэлж байна.

Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл

Санхүүгийн хэрэглүүр

Нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгад тусгагдсан бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэлгээний шатлалын дагуу ангилдаг бөгөөд энэхүү шатлал нь бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан өгөгдлийн ач холбогдлыг илэрхийлнэ. Үүнд:

- a) Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх ижил хөрөнгө эсвэл өр төлбөрийн үнийн санал (тохируулаагүй)
- b) Түвшин 2: Түвшин 1-д багтсан үнийн саналаас бусад өгөгдөл, үүнд шууд (жишээ нь үнэлгээ), эсвэл шууд бус (үнэлгээнээс үүдэлтэй) хөрөнгө эсвэл өр төлбөр багтсан
- c) Түвшин 3: Зах зээлийн өгөгдлөөр ажиглах боломжгүй хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдлүүд

Бодит үнэ цэн

2023 болон 2024 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн хугацаанд 1, 2, 3-р түвшинд ангилсан хөрөнгө, өр төлбөрийн хооронд шилжүүлэг хийгдээгүй. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн нь богино хугацаанд санхүүгийн хэрэглүүрийн хугацаа дуусахад дансны үнэ цэнтэй ойролцоо байна.

Зээлийн эрсдэл

Компани нь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын томоохон санхүүгийн институтэд хадгалуулж, бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулах боломжтой гэж Компанийн удирдлага үздэг. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар бэлэн мөнгөний үлдэгдлийн 2% буюу \$121,756 нь Канад Улсаас гадна банкуудад хадгалагдаж байна (2023 - \$33,759 буюу 1%).

Хөрвөх чадварын эрсдэл

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг. Компанийн бүх санхүүгийн өр төлбөрийг ирэх арван хоёр сарын дотор барагдуулахаар төлөвлөж байна.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

Хүүгийн эрсдэл

Компанийн одоогийн баримталж буй бодлого нь хүүгийн эрсдэлд орох боломжтой илүүдэл бэлэн мөнгийг хүүтэй хадгаламжийн дансанд байршуулж байна.

Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин, хараат компанийн голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг; хуримтлагдсан өр төлбөр болон Монгол дахь хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт багтаж байна.

Компанийн ам.долларын валютын эрсдэлд өртөх байдал нь 2024 оны 12 сарын 31-нд \$401,688 (2023.12.31 - \$1,044,829) буюу ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$40,200 долларын цэвэр алдагдал (ашиг) дагуулах магадлалтай (2023.12.31 - \$104,500).

Компанийн төгрөгийн эрсдэлд өртөх байдал нь 2024 оны 12 сарын 31-нд \$25,393 (2023.12.31 - \$2,966) буюу төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$2,500 долларын цэвэр алдагдал (ашиг) дагуулах магадлалтай (2023.12.31 - \$300).

Үнийн эрсдэл

Компани нь тодорхой ашиггүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэгсэл, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

Бусад эрсдэлүүд

Компани нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа голчлон хайгуулын үр дүн, тусгай зөвшөөрөл, санхүүжилттэй холбоотой эрсдэлтэй тулгардаг, түүнээс гадна металл болон түүхий эдийн үнэтэй холбоотой эрсдэл, тодорхой бус байдал үүсэх боломжтой. Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт нь олон эрсдэл дагуулдаг бөгөөд дийлэнх нь Компанийн хяналтаас давсан байдаг. Компани нь дэд бүтэц сул хөгжсөн алслагдмал байршилд үйл ажиллагаа явуулдаг гадна хайгуул, ашиглалтын энгийн эрсдэлүүдтэй тулгарч байдаг. Эдгээр эрсдэлүүдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR+ www.sedarplus.ca-д байрлах Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс танилцах боломжтой.

Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт

Канадын үнэт цаасны зохицуулалтын 52-109 журмын дагуу санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал (ГЗ), Санхүү хариуцсан захирал (СХЗ)-ыг багтаасан Эрдэнэ Ресурсийн удирдах баг (хамтад нь “Удирдах баг” гэх) нь 2024 оны 12 сарын 31-ээр санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж, компани болон түүний охин компаниудтай холбоотой материаллаг мэдээллийг шаардлагатай талд мэдүүлж, үнэн зөв бүрэн тодруулах боломжтой гэсэн баталгааг гаргахад хангалттай гэж дүгнэсэн.

ГЗ болон СХЗ-ын хамтаар компанийн удирдлага нь санхүүгийн тайлагналд дотоод хяналтыг бий болгох, хангаж ажиллах үүрэгтэй. Санхүүгийн тайлагналд тавих Эрдэнэ Ресурсийн дотоод хяналт (аудит) нь санхүүгийн тайлагналын найдвартай байдлыг хангаж, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд анхаарна.

Удирдлага нь 2024 оны 12 сарын 31-ний байдлаар Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ийнхүү үнэлэхдээ Удирдлага нь (“Committee of Sponsoring Organizations of the Treadway Commission”) “Дотоод хяналт - нэгдсэн зохицуулалтын орчин (2013)” гэх тайланд тогтоосон шалгууруудыг ашигласан. Үнэлгээгээр гол эрсдэлтэй салбаруудын хяналтыг шалгаж, эдгээр хяналтуудын хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөг нь тодорхойлох зорилгоор тэдгээр хяналтуудыг туршиж, үр дүнг нь хянаж, улмаар нэгдсэн дүгнэлт гаргасан.

Удирдлагын үнэлгээнд үндэслэн ГЗ болон СХЗ нар 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт болон материаллаг сул тал нь санхүүгийн тайлагналын үнэн зөв, найдвартай байдлыг хангах, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд үр нөлөөтэй байна гэж дүгнэсэн.

Үр дүнтэй хэмээн тодорхойлсон систем нь санхүүгийн тайлангийн бэлтгэл, танилцуулгатай холбоотойгоор баталгааг зөвхөн тодорхой хэмжээнд өгөх боломжтой. Түүнчлэн, ирээдүйн үр дүнтэй байдлын үнэлгээний төсөөлөл нь нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хяналт буурах, эсвэл бодлого, дүрэм журмын хэрэгжилт муудах эрсдлүүд бий.

Мэргэшсэн этгээд

Петер Далтон, Р.Гео, (Нова Скошиа) нь NI 43-101 стандартын шаардлага хангасан мэргэшсэн этгээд бөгөөд Компанийн хайгуулын бүх геологийн хөтөлбөрийг удирдан чиглүүлнэ. Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хот эсвэл БНХАУ-ын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори (“SGS Laboratories”), Улаанбаатар хот дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Коуст Рисерч Лтд (“Blue Coast Research Ltd”) эсвэл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн эрдэсжилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэдэг.

Энэхүү УХДШ-д толилуулсан Компанийн эзэмшиж буй ашигт малтмалын төслүүдийн шинжлэх ухааны болон техникийн мэдээллийг Компанийн мэргэшсэн мэргэжилтэн Петер Далтон (Р.Гео) хянан баталсан болно.

Энэхүү УХДШ-д багтсан Баянхөндий ордын ТЭЗҮ-ийн санхүүгийн загвартай холбоотой мэдээлэл нь O2 Mining Limited-ийн ажилтан Марк Рэйнолдс (“Mark Reynolds”)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. Энэхүү УХДШ дэх Баянхөндий ордын ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны зардлын тооцоотой холбоотой мэдээлэл нь FAusIMM ба O2 Mining Ltd компанийн захирал Жулиен Лауренс (Julien Lawrence)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. Энэхүү УХДШ дэх Баянхөндий ордын ТЭЗҮ-ийн боловсруулах үйлдвэрийн загварчлал болон алт авалтын аргачлалтай холбоотой мэдээллийг FAusIMM-ийн гишүүн ба O2 Майнинг ХХК-тай хамтран ажилладаг Жеффри Жардин (Jeffrey Jardine)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд үндэслэсэн болно. УХДШ дэх Баянхөндий ордын нөөцийн тооцооллыг AGP Mining Consultants Inc-ийн ажилтан Пол Даигл (“Paul Daigle”), Р.Гео, боловсруулж, баталгаажуулсан. Баянхөндийн геологийн нөөцийн тооцооллыг Австралийн газар зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, RPM Global компанийн ажилтан БатОчирын Оюунбат (“Oyunbat Bat-Ochir”) боловсруулж баталгаажуулсан. Баянхөндийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллыг Жулиен Лауренс (Julien Lawrence)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. н.Рэйнолдс, Лауренс, Жардин, Даигл ба БатОчир нар нь энэ төрлийн орд болон эрдэсжилтийн төрлийн талаар өндөр мэдлэг туршлагатай, NI 43-101-г тодорхойлсон мэргэшсэн мэргэжилтнүүд юм. Ноён Рэйнолдс, Лауренс, Жардин, Даигл ба Бат-Очир нар нь Эрдэнэ Ресурстай холбоотой ашиг сонирхлын зөрчилгүй.

Бусад мэдээлэл

Компанийн талаарх нэмэлт мэдээллийг SEDAR+ www.sedarplus.ca хаяг болон www.erdene.com хаяг дахь Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс үзэх боломжтой.

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө

Хавсралт - Хүдрийн хяналтын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгүүд

Цооног	*Зүүн	*Хойд	м-ээс	м хүртэл	**интервал	г/т алт
Баганат өрөмдлөгийн цооног						
ВКDH-80	483372	4861183	1.9	6	4.1	5.99
үүнд			1.9	3	1.1	11.50
ВКDH-81	483372	4861178	0.4	10	9.6	26.86
үүнд			6	7	1	253.00
ВКDH-148	483357	4861188	0	10	10	4.98
үүнд			8	10	2	23.40
ВКDH-163	483352	4861257	4.85	8	3.15	9.52
үүнд			4.85	6	1.15	24.40
ВКDH-165	483352	4861238	0.13	4	3.87	6.70
үүнд			0.13	1	0.87	14.50
ВКDH-169	483352	4861208	0.8	10	9.2	2.63
үүнд			0.8	2	1.2	12.40
ВКDH-170	483352	4861203	0.4	10	9.6	2.96
үүнд			8	9	1	14.50
ВКDH-192	483347	4861248	1.7	5	3.3	6.14
үүнд			3	4	1	17.00
ВКDH-195	483347	4861233	0.3	6	5.7	3.82
ВКDH-715	483187	4861033	9	14	5	4.16
үүнд			11	12	1	17.30
Урвуу үлээлгэт хийн цохилтот эргэлтэт цооног						
ВКGC-3	483422	4861087	0	4	4	6.34
үүнд			1	2	1	22.20
ВКGC-47	483382	4861113	1	11	10	2.39
ВКGC-50	483382	4861088	0	4	4	25.08
үүнд			3	4	1	97.80
ВКGC-55	483382	4861063	9	13	4	6.59
үүнд			10	11	1	21.80
ВКGC-58	483382	4861047	5	12	7	59.49
үүнд			7	11	4	100.99
үүнд			7	8	1	336.00
ВКGC-61	483377	4861123	0	10	10	3.70
үүнд			2	3	1	15.00
ВКGC-73	483377	4861048	1	6	5	4.24
үүнд			2	3	1	16.30
ВКGC-85	483372	4861122	0	2	2	10.48
үүнд			1	2	1	19.70
ВКGC-86	483372	4861118	4	12	8	3.06
үүнд			4	5	1	17.10
ВКGC-109	483367	4861118	1	11	10	10.37
үүнд			2	3	1	77.00
ВКGC-153	483357	4861118	0	6	6	8.14
үүнд			3	4	1	42.40
ВКGC-154	483357	4861113	4	12	8	3.81

Цооног	*Зүүн	*Хойд	м-ээс	м хүртэл	**интервал	г/т алт
үүнд			6	8	2	10.90
ВКGC-178	483352	4861113	4	13	9	9.22
үүнд			4	6	2	37.05
ВКGC-235	483342	4861107	8	14	6	7.03
үүнд			10	11	1	35.40
ВКGC-274	483332	4861078	6	12	6	7.22
үүнд			10	11	1	39.00
ВКGC-286	483327	4861107	11	15	4	115.14
үүнд			11	14	3	151.47
үүнд			11	12	1	390.00
ВКGC-287	483327	4861102	14	15	1	99.40
ВКGC-294	483322	4861113	8	15	7	28.36
үүнд			8	9	1	183.00
ВКGC-297	483322	4861098	0	3	3	7.00
үүнд			0	1	1	10.30
ВКGC-304	483322	4861018	0	16	16	5.14
үүнд			1	2	1	14.40
үүнд			7	8	1	19.20
үүнд			9	10	1	19.00
ВКGC-310	483317	4861123	3	7	4	25.06
үүнд			3	4	1	98.20
ВКGC-311	483317	4861118	4	12	8	4.98
үүнд			7	9	2	13.60
ВКGC-318	483318	4861028	12	15	3	16.09
үүнд			13	14	1	43.30
ВКGC-319	483317	4861022	0	15	15	1.90
үүнд			8	9	1	11.30
ВКGC-321	483312	4861128	1	14	13	3.45
үүнд			6	8	2	15.70
ВКGC-323	483312	4861118	5	14	9	5.02
үүнд			6	7	1	16.80
ВКGC-334	483311	4861022	0	10	10	2.22
ВКGC-429	483282	4861018	0	4	4	8.08
үүнд			2	3	1	22.10
ВКGC-430	483282	4861012	0	8	8	3.38
үүнд			3	4	1	10.40
ВКGC-432	483282	4861002	3	11	8	3.97
үүнд			8	9	1	16.90
ВКGC-439	483281	4860948	0	9	9	2.74
ВКGC-440	483282	4860942	0	19	19	4.02
үүнд			13	15	2	20.30
ВКGC-441	483281	4860937	4	11	7	3.63
үүнд			8	9	1	21.10
ВКGC-456	483277	4860952	0	14	14	4.05
үүнд			0	3	3	11.20

Цооног	*Зүүн	*Хойд	м-ээс	м хүртэл	**интервал	г/т алт
үүнд			7	8	1	10.60
BKGC-464	483272	4861058	1	13	12	2.00
BKGC-498	483267	4861013	14	24	10	2.34
BKGC-502	483268	4860979	12	17	5	13.69
үүнд			15	16	1	64.40
BKGC-505	483267	4860963	0	26	26	3.45
үүнд			11	12	1	52.90
BKGC-506	483266	4860957	0	24	24	3.70
үүнд			13	15	2	15.05
BKGC-507	483267	4860953	0	22	22	2.64
BKGC-509	483267	4860937	1	13	12	4.26
үүнд			3	4	1	20.10
үүнд			7	8	1	16.60
BKGC-529	483262	4860988	0	16	16	1.90
BKGC-532	483262	4860973	0	22	22	2.20
үүнд			2	3	1	11.10
BKGC-534	483262	4860963	0	21	21	1.75
BKGC-535	483262	4860957	0	17	17	2.10
BKGC-536	483262	4860952	0	22	22	2.23
BKGC-537	483262	4860948	0	20	20	27.81
үүнд			7	9	2	173.00
үүнд			10	12	2	91.15
үүнд			11	12	1	171.00
BKGC-538	483262	4860937	0	11	11	2.64
үүнд			6	7	1	16.70
BKGC-548	483256	4860982	0	18	18	2.81
үүнд			9	10	1	30.30
BKGC-553	483257	4860957	0	12	12	2.20
BKGC-555	483257	4860937	0	16	16	1.46
BKGC-559-V	483252	4861047	4	8	4	5.28
үүнд			5	6	1	11.00
BKGC-569	483252	4860983	0	5	5	11.42
үүнд			1	2	1	46.10
үүнд			4	5	1	10.10
BKGC-575	483252	4860948	0	19	19	15.65
үүнд			1	3	2	15.20
үүнд			4	8	4	56.05
үүнд			9	10	1	10.50
BKGC-576	483252	4860943	0	18	18	1.38
BKGC-583	483247	4861027	0	7	7	4.13
үүнд			2	3	1	17.60
BKGC-586	483247	4860953	0	16	16	2.22
BKGC-587	483247	4860948	0	17	17	1.74
BKGC-588	483247	4860943	1	16	15	3.78
үүнд			4	5	1	30.90

Цооног	*Зүүн	*Хойд	м-ээс	м хүртэл	**интервал	г/т алт
ВКGC-596	483243	4861043	1	13	12	2.24
ВКGC-600	483242	4861023	0	7	7	3.19
үүнд			3	4	1	12.00
ВКGC-607	483242	4860957	0	18	18	2.55
ВКGC-608	483242	4860952	1	13	12	2.92
үүнд			11	12	1	18.60
ВКGC-610	483237	4861048	0	11	11	1.99
үүнд			7	8	1	11.90
ВКGC-611	483237	4861043	0	12	12	6.32
үүнд			4	5	1	57.20
ВКGC-618	483237	4860957	0	7	7	4.46
үүнд			2	3	1	13.20
ВКGC-620	483232	4861047	0	14	14	2.52
үүнд			3	4	1	14.20
үүнд			8	9	1	10.20
ВКGC-622	483233	4861039	6	14	8	3.78
үүнд			9	10	1	15.90
ВКGC-627	483232	4861013	9	17	8	2.75
үүнд			11	12	1	17.10
ВКGC-631	483232	4860947	11	15	4	11.66
үүнд			11	12	1	41.10
ВКGC-666	483207	4861038	0	13	13	3.73
ВКGC-667	483207	4861032	0	16	16	6.42
үүнд			5	7	2	24.10
ВКGC-679	483202	4861047	1	4	3	8.86
үүнд			2	3	1	26.20
ВКGC-681	483202	4861038	0	17	17	4.56
үүнд			2	4	2	13.60
ВКGC-683	483203	4861029	8	17	9	2.92
үүнд			9	10	1	11.50
ВКGC-692	483197	4861037	0	16	16	3.15
үүнд			1	2	1	11.40
үүнд			15	16	1	21.90
ВКGC-698	483192	4861063	0	4	4	13.14
үүнд			0	2	2	22.80
ВКGC-702	483192	4861042	3	13	10	2.86
үүнд			4	5	1	21.70
ВКGC-709	483187	4861062	0	8	8	3.57
ВКGC-710	483187	4861057	3	9	6	14.84
үүнд			5	7	2	40.55
ВКGC-725	483182	4861052	6	14	8	15.47
үүнд			8	10	2	57.75
ВКGC-726	483182	4861048	5	14	9	2.52
үүнд			9	10	1	11.60

Цооног	*Зүүн	*Хойд	м-ээс	м хүртэл	**интервал	г/т алт
ВКGC-773	483262	4860927	0	15	15	2.82
үүнд			0	1	1	11.30
үүнд			13	14	1	13.60
ВКGC-790	483247	4860928	5	14	9	3.70
үүнд			12	13	1	18.00
ВКGC-794	483242	4860943	0	15	15	2.69
ВКGC-796	483242	4860932	7	14	7	6.40
үүнд			11	12	1	21.50
ВКGC-799	483242	4860913	2	8	6	22.52
үүнд			4	6	2	61.55
ВКGC-801	483237	4860942	8	14	6	37.23
үүнд			8	9	1	12.80
үүнд			11	12	1	206.00
ВКGC-805	483237	4860923	0	5	5	4.74
үүнд			1	2	1	17.70
ВКGC-806	483237	4860917	4	11	7	6.16
үүнд			5	6	1	27.50
ВКGC-811	483232	4860923	1	6	5	4.50
ВКGC-826	483222	4860918	2	12	10	8.44
үүнд			3	4	1	15.30
үүнд			6	10	4	16.40
ВКGC-827	483222	4860913	2	12	10	79.81
үүнд			5	6	1	770.00
үүнд			10	11	1	19.40
ВКGC-848	483207	4860918	7	12	5	9.69
үүнд			7	9	2	21.95
ВКGC-892	483162	4860943	0	8	8	37.29
үүнд			3	5	2	144.70
үүнд			4	5	1	262.00
ВКGC-910	483177	4861057	4	14	10	6.47
үүнд			7	8	1	25.70
үүнд			11	12	1	23.00
ВКGC-940	483382	4861178	6	9	3	9.38
үүнд			6	7	1	26.50
ВКGC-941	483382	4861173	3	8	5	7.46
үүнд			3	6	3	11.90
ВКGC-953	483397	4861133	2	6	4	7.54
үүнд			2	4	2	13.60

*Агуулгын хяналтын өрөмдлөгийн цооногийн байршлуудыг тодорхойлох зүүн болон хойд чиглэлийн координатуудад WGS 84 Zone 47N дата ашигласан.

** Дийлэнх цооногуудыг -60 уналт, 030 азимутаар өрөмдсөн. Ордын геологийн хэлбэлзлийн улмаас мэдээлсэн бүх интервалыг цооногийн жинхэнэ зузааны 80-100% гэж тайлбарлаж болно.